



**“МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ III ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН**



Улаанбаатар хот
2025 оны 10 дугаар сарын 28

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК (МГТБҮ) нь Газрын тос боловсруулах үйлдвэр (ГТБҮ), Газрын тос дамжуулах хоолой, үйлдвэрийн гаднах дэд бүтцийн байгууламжууд, “Газрын тосны үйлдвэрийн хотхон” байгуулах төслүүдийг хэрэгжүүлж байна. Түүнээс гадна газрын тосны дээш урсгал болох хайгуул, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эхлүүлэхээр ажиллаж байна.

Олон салбар дамнасан, цогц үйл ажиллагааг хамрах энэхүү бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн инженерчлэлийн ажилд Энэтхэг, Итали, Франц, Герман, Их Британи, АНУ, Канад, Нидерланд, Испани, БНХАУ зэрэг 10 гаруй улс орны олон тооны инженер, мэргэжилтнүүд оролцон ажиллаж байна.

Үйлдвэрийн ЕРС 01 багц ажил бүрэн дуусч, 2024 онд улсын комисст хүлээлгэн өгснөөр зориулалтын дагуу ашиглагдаж эхэлсэн. ЕРС 02, ЕРС 03, ЕРС 04 багц ажлын хувьд инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж байна. Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажил 89,4 хувьд хүрсэн.

ГТБҮ болон Газрын тос дамжуулах хоолой, Газрын тосны үйлдвэрийн хотхоны бүтээн байгуулалтын ажилд 3500 орчим хүн ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьд 100 гаруй хүний орон тоотойгоор үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Мөн БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Сангийн яам, Энэтхэгийн Экспорт-Импортын банкны удирдлагууд ГТБҮ-ийн төслийн явцыг тогтмол хянан, бүтээн байгуулалтын талбайд биечлэн ажиллаж, Төсөл хэрэгжүүлэгч компани, Төслийн менежментийн зөвлөх болон Ерөнхий гүйцэтгэгч компанийн удирдлагуудтай менежментийн түвшинд хурал уулзалтууд хийж, тулгамдсан асуудлуудыг хамтран шийдвэрлэж байна.

НЭГ. ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

ГТБҮ-ийн барилга байгууламжуудын төвөгшил, дэс дараалал, инженерчлэлийн ажилд зарцуулагдах хугацааг харгалзан, бүтээн байгуулалтын ажлыг дараах 4 хэсэгт хуваан хэрэгжүүлж байна. Үүнд:

ЕРС 01: Технологийн бус барилга байгууламж

ЕРС 02: Атмосферийн болон Вакум нэрлэг, Ханасан хий ялгах байгууламж, дагалдах, туслах байгууламжууд

ЕРС 03: Үйлдвэрийн Дулааны цахилгаан станц

ЕРС 04: Лицензтэй технологийн байгууламжууд

ГТБҮ-ийн бүтээн байгуулалтын Төслийн Менежментийн зөвлөх (ТМЗ)-өөр БНЭУ-ын төрийн өмчит “Engineers India Limited” (EIL) компани ажиллаж байна. ЕРС 02, 03 ба 04 багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгчээр БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (MEIL) компани, Газрын тос дамжуулах хоолойн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Norinco International Limited” компани тус тус ажиллаж байгаа ба Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлуудыг Испани улсын “Intecsa Industrial” S.A., Италийн “STF Termotechnica”, Их Британийн Foster Wheeler, БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited”, Канад улсын “Worley Parsons” зэрэг компаниуд гүйцэтгэж байна.

1.1. ЕРС 01 БАГЦ АЖИЛ - Технологийн бус барилга байгууламжууд

ЕРС 01 багц ажлын ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Kalpataru Projects International Limited” (KPIL) компани 2024 онд ажлаа бүрэн дуусгаж, тус оны 11 сард бүх барилга байгууламжаа байнгын ашиглалтанд хүлээн авч дууссан бөгөөд тухайн барилга байгууламжийн зүгшрүүлэлт, тохируулгын хугацаа дуусах дөхөж байна.

Энэ хугацаанд гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, шаардлагатай тохиолдолд сайжруулах ажиллагааг ТМЗ болон гүйцэтгэгч компанитай хамтран үзлэг шалгалтуудыг хийж, баталгаажуулан ажиллаж байна.

ЕРС 01 багц ажлын барилга байгууламжууд



ЕРС 01 багц ажлын хүрээнд баригдсан объектуудын ашиглалт, арчлалт, хамгаалалт:

ЕРС 01 багц ажлын хүрээнд шинээр бий болсон өмч хөрөнгийн ашиглалт, арчлалт, хамгаалалтын зардлыг ашиглалтад орсон зарим барилгыг үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж буй Ерөнхий гүйцэтгэгч компанид түрээслүүлэх замаар объектуудын ашиглалтын зардлын дийлэнх хувийг шийдвэрлэж байна.

Харин Бор Хөөвөрийн говь дахь ус хангамжийн эх үүсвэрийн системийн дэд бүтэц, барилга байгууламж (89,9 км шугам хоолой, түүнийг дагасан 11 худаг, ЦДАШ)-ийн харуул хамгаалалтыг МГТБҮ ТӨХХК өөрийн нөөц боломжийн хүрээнд техникийн болон хамгаалалтын 8 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байна.

1.2. ЕРС 02 БАГЦ АЖИЛ - Анхдагч технологийн болон дагалдах, туслах, хангамжийн байгууламжууд

Тус багц ажлын хүрээнд үйлдвэрийн анхдагч технологийн байгууламжууд, дагалдах, хангамжийн байгууламжууд ба агуулах сав парк, бамбарын систем, ачих буулгах байгууламжуудыг барьж байгуулах ажил хийгдэж байна. Эдгээр байгууламж тус бүрийн инженерчлэл, тооцоолол, зураг төслийн ажил сайн явагдаж байна.

ЕРС 02 багц ажлын хүрээнд баригдах барилга байгууламжууд:

- Атмосферийн болон Вакуум нэрлэгийн байгууламжууд, Ханасан хий ялгах байгууламж;
- Агуулах сав паркийн 7 хэсэг бүхэлдээ (түүхий эд, завсрын бүтээгдэхүүн, эцсийн бүтээгдэхүүн хадгалах сав парк, мөн төрөл бүрийн хэмжээтэй шугам хоолой, тулгуур гэх мэт.);
- Иргэний барилга, байгууламжууд, тухайлбал ууршуулах талбай, хатуу хог хаягдлын байгууламж, шугам хоолойн эстакад, насосын станц, төв удирдлагын барилга, дэд станцууд (№1, 3, 4, 6) болон хяналтын барилгууд;
- Ачих, буулгах байгууламж, (эцсийн бүтээгдэхүүн болох пропан, бутан, автобензин, Jet A-1, дизель түлшийг ачих, буулгах гарууд, холбогдох тоноглолууд, авто болон вагон эстакадууд) ;
- Хангамжийн байгууламжууд (Ус цэвэршүүлэх байгууламж, цэвэршүүлсэн усыг эрдэсгүйжүүлэх байгууламж, хөргөлтийн усны систем, галын ус хадгалах далд резервуар, уур, бойлерын ус, халууны усны систем, бамбарын систем, түлшний систем, даралтат агаарын систем, азотын систем, бохирдсон ус цэвэрлэх байгууламжууд багтана.)

1.2.1. НАРИЙВЧИЛСАН ИНЖЕНЕРЧЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ

Тус багц ажлын ерөнхий гүйцэтгэгч MEIL компаниас ЕРС 02 багц ажлын тоног төхөөрөмжтэй холбоотой 1131 ширхэг, 203 багц техникийн бичиг баримтыг (инженерийн зураг төслүүд, процесс болон механикийн өгөгдлүүд гэх мэт) 2025 оны III улиралд, нийтдээ энэ онд 8196 ширхэг, 1471 багц техникийн бичиг баримт хүлээн авч ТМЗ-ийн хамт хянан, санал шаардлагаа хүргүүлэн ажиллаж байна.

2025 оны III улирлын байдлаар техник, тоног төхөөрөмжүүд, барилга байгууламжийн нарийвчилсан инженерчлэлийн зураг төсөл, тооцооллыг ерөнхий гүйцэтгэгч, инженерчлэлийн компани, үйлдвэрлэгч, нийлүүлэгч нар хамтран гүйцэтгэж, МГТБҮ нь ТМЗ-тэй хамтран хянан баталгаажуулж байна. Барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдийн

зураг төсөл, техникийн тодорхойлолт, баталгаажуулалтын гүйцэтгэлийг доорх хүснэгтээр үзүүлэв.

Нарийвчилсан инженерчлэл, зураг төсөл

№	Тоног төхөөрөмж төрөл	Процессын байгууламж		Хангамжийн байгууламж		Дагалдах байгууламж	
		Төлөвлөгөө %	Бодит, %	Төлөвлөгөө %	Бодит, %	Төлөвлөгөө %	Бодит, %
1	Иргэний барилга байгууламж	20.0	18.5	20.0	16.9	20.0	19.7
2	Шугам хоолой	30.0	27.9	30.0	24.9	30.0	27.8
3	Суурин тоног төхөөрөмж	12.0	11.3	5.0	3.4	12.0	10.2
4	Эргэлтэт тоног төхөөрөмж	10.0	9.9	12.0	11.0	10.0	9.6
5	Даралтат сав, дулаан солилцуур, хадгалах сав, резервуар	5.0	4.7	10.0	7.1	8.0	7.9
6	Механик багц	8.0	7.6	8.0	5.8	5.0	4.4
7	Цахилгаан	8.0	6.3	8.0	6.5	8.0	5.9
8	Тоноглол	7.0	6.0	7.0	4.0	7.0	4.8
Нийт		100.0	92.3	100.0	80.0	100.0	90.7

МГТБҮ, Ерөнхий гүйцэтгэгч MEIL болон ТМЗ нь ЕРС 02, 03 багц ажлын техникийн хурлыг 7 хоног, сар тутамд тогтмол зохион байгуулж, ажлын явцыг хамтран хянан хэлэлцэж, асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байна.

1.2.2. 3D ЗАГВАРЧЛАЛ

ТМЗ компани болон ЕРС 02 багц ажлын ерөнхий гүйцэтгэгч MEIL компанийн төлөөлөлтэй хамтран Атмосферийн болон Вакуум нэрлэг, Ханасан хий ялгах байгууламжийн инженерчлэлийн 3D загварчлалын 2-р шатны гүйцэтгэлийн хүрээнд хийгдэх тоног төхөөрөмжүүдийн загварчлал, тэдгээрийн шугам хоолойн гаргалгаа, шугам хоолойн эстакад, хоёр инчээс дээш бүх шугам хоолойн хийц, далд шугам хоолойн систем, тоног төхөөрөмжүүдийн хэмжүүр автоматжуулалт, тэдгээрийн цахилгаан хангамжийн загварчлалыг хэлэлцэх техникийн хурал, уулзалтыг хийж, гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан.

3D загварчлал нь барилга угсралт, тоног төхөөрөмж, шугам хоолойн угсралтын ажлыг хөнгөвчлөх, барилга угсралтын үед гарч болзошгүй алдааг тах. хэмжээнд бууруулах, ашиглалтын үед засвар үйлчилгээний нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг тодорхой болгох зорилгоор хийгддэг хамгийн сүүлийн шатны дижитал бодит модель (exact digital replica) юм.

Атмосфер болон Вакуум нэрлэгийн байгууламж, дагалдах, туслах, хангамжийн байгууламжуудын инженерчлэлийн 3D загварчлалын 2-р шатны гүйцэтгэлийг хянах техникийн хурлаар иргэний болон технологийн барилга байгууламжийн хийц бүтээц, процесс, шугам хоолой болон автоматжуулалтын инженерүүд асуудлуудыг хэлэлцэж, дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:

- 3D загварчлалын 1-р шатны гүйцэтгэл дээрх хийгдэх бүх ажлыг хянаж эцэслэн дуусгах арга хэмжээ авсан;

- 3D загварчлалын 2-р шатны ажлын даалгаварт тусгагдсан бүх ажлууд хийгдсэн эсэхийг хянасан;
- Нэрлэгийн байгууламж, түүний тоног төхөөрөмжийн бүтээцэд зарим шаардлагатай өөрчлөлт хийх ажлыг гүйцэтгэсэн.

3D загварчлалын 1, 2-р шатны гүйцэтгэлийг хянан шалгах хурлаас өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт:

3D загварчлалын 1-р шатны гүйцэтгэлийн зөвлөмж:

- Дагалдах байгууламж: Нийт 246 зөвлөмжөөс 242 нь биелэгдсэн, 4 нь хүлээгдэж байна.
- Атмосфер болон вакум нэрлэгийн байгууламж: Нийт 341 зөвлөмжөөс 330 биелэгдсэн 11 нь хүлээгдэж байна.


3D загварчлалын 2-р шатны гүйцэтгэлийн зөвлөмж:

- Дагалдах байгууламж: Нийт 315 зөвлөмжөөс 253 нь биелэгдсэн, 62 нь хүлээгдэж байна.
- Атмосфер болон вакум нэрлэгийн байгууламж: Нийт 269 зөвлөмжөөс 237 нь биелэгдсэн, 32 зөвлөмж хүлээгдэж байна.

2025 оны III улирлын байдлаар 3D загварчлалын 1 болон 2-р шатны хяналтын хүрээнд нийт дөрвөн чиглэлээр өгөгдсөн 1171 зөвлөмжөөс 1062 нь биелэгдэж, 109 зөвлөмж хүлээгдэж байгаа нь нийт зөвлөмжийн 90.7% нь биелэгдсэн, 9.3% нь хэрэгжилтийн шатанд байгааг харуулж байна. Тухайлбал, Атмосфер болон Вакуум нэрлэг, дагалдах, туслах, хангамжийн байгууламжуудад өгөгдсөн зөвлөмжүүдийн ихэнх нь хяналтын хугацаанд үр дүнтэй хэрэгжиж, зураг төсөл, байршил төлөвлөлт, инженерчлэлийн шийдэлтэй холбоотой гол асуудлууд шийдвэрлэгдсэн. Харин хүлээгдэж буй зөвлөмжүүд нь суурилуулалтын шатны өмнө шийдвэрлэх шаардлагатай нарийн төвөгтэй зохицуулалт, инженерчлэлийн асуудлууд байгаа тул нэмэлт хэлэлцүүлэг, нарийвчилсан шийдэл хийгдэж байна.

Дээрх хурлын үр дүнд гарсан 3D загварчлалтай холбоотой шийдвэр, баримт бичиг болон хавсралтуудыг MEIL компани тогтмол шинэчлэн ирүүлж ажилласан. Тодруулбал, III улиралд буюу 07 дугаар сарын 25-наас 09 дүгээр сарын 12-ны хооронд нийт 4 удаа холбогдох материалуудыг шинэчлэн ирүүлсэн бөгөөд эдгээр нь зураг төслийн нарийвчлалыг ахиулах, инженерчлэлийн шийдлүүдийг уялдуулах болон төслийн явцыг тодорхой түвшинд баталгаажуулахад чиглэгдсэн болно.

3D загварчлалын ажлын хүрээнд өгсөн зөвлөмжүүдийн дагуу шинэчилж ирүүлсэн хувилбар




Технологийн зуухны 3D загварчлал

Атмосфер болон Вакуум нэрлэгийн байгууламжийн технологийн зуухны (101-H-1001, 101-H-1002 дугаартай) нийлүүлэгчээр Франц улсын *Heurtey Petrochem* компани шалгарсан. 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр тус компани болон ерөнхий гүйцэтгэгч MEIL, (ТМЗ) EIL-ийн хамт тус зуухны 3D загварчлалын 1-р шатны техникийн хурлыг товлосон хугацаанд хийсэн.

Технологийн зуухны 3D загварчлалын 1-р шатны гүйцэтгэлд 12 төрлийн шаардлагыг загварчилсан байх. Үүнд:

- Бүх тоног төхөөрөмжийг байрлуулсан байх (уурын шугам, процесс шугам);
- Бүх багц тоноглол, асаагуур, агаар урьдчилан халаагч, сэнс;
- Засвар үйлчилгээ хийх талбай;
- Тавцан, шат, тулгуур;
- Асаагуурын түлшний шугамын зохион байгуулалт хийгдсэн байх;
- Зуухны гол тавцан, яндан

Технологийн Зуухны 3D загварчлал (дээрээс болон хажуунаас харсан зураг)



2025.02.27,28-ны өдрүүдэд технологийн зуухны аюул эрсдэлийн болон нөхцөлт боломжийн задлан шинжилгээний (HAZOP) онлайн хурлыг *Heurtey Petrochem*, MEIL, ТМЗ-ийн хамт төлөвлөсөн хугацаанд амжилттай зохион байгуулагдсан. Энэхүү хурлын өмнө гүйцэтгэгч компаниас Marked P&ID буюу зуухны шугам хоолой тоноглолын диаграмм (10 ширхэг зураг агуулсан файл) ирүүлсэн.

Азот, даралтат хийн байгууламжийн 3D загварчлал

Азотын хий үйлдвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж нийлүүлэгчээр БНЭУ-ын LINDE компани сонгогдсон бөгөөд зураг төсөл, 3D загварчлал, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл хуваарийн дагуу хийгдэж байна.

- Ерөнхий гүйцэтгэгч – MEIL компани;
- Инженерчлэл, зураг төслийг – INTECSA компани;
- Тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг – дэлхийд тэргүүлэгч LINDE компани нийлүүлж байна.

1.2.3. ХУДАЛДАН АВАЛТ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАТЕРИАЛЫН ЗАХИАЛГА, ҮЙЛДВЭРЛЭЛ

ЕРС 02 багц ажлын технологийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн захиалга, худалдан авалт, 2025 оны III улирлын байдлаар:

Захиалга, худалдан авалтын нэгтгэл

Тоног төхөөрөмжийн нэр		Нийлүүлэгчийн нэр	Захиалга	Тоо, ширхэг
Дулаан солилцуур (материалын төрөл SS316)		UNITED COOLING SYSTM PVT. LTD, COIMBATORE	2025/01/10	2
Холигч (JET MIXERS)		M.K.DESIGN & ENGG CO, THANE	2025/02/01	50
Ус хангамжийн блок (Түүхий ус цэвэршүүлэх, эрдэсгүйжүүлэх, бохир ус цэвэршүүлэх байгууламжууд)		SPARKLE CLEAN TECH PVT. LTD, BELAPUR, NAVI MUMBAIL	2025/02/01	Блок байгууламж
Насос (Pump)		KEPL	2025.04.30	46
Ус цэвэршүүлэх багц төхөөрөмжийн захиалга (Water Block Package)		Sparkle Clean Tech Pvt. Ltd (Belapur, Navi Mumbai)	2025.05.05	Багц тоноглол
101-C-1004 коллоны доторх төхөөрөмж (Column Internals)		Sulzer India Pvt. Ltd (Kondhapuri, Pune)	2025.05.06	Багц тоноглол
Газар доорх болон галын хоолой (UG & FF pipes)		Kirloskar Ferrous Industries Ltd (Pune)	2025.05.23	16,952м
UG & FF pipes		Maharashtra Seamless Ltd	2025.06.07	5,859м
UG & FF pipes		Ratnamani Metals and Tubes Ltd	2025.06.09	14,977м
Агаар хөргөгч (Air Cooler)		United Cooling Systems Pvt. Ltd (Coimbatore)	2025.06.10	10
Сорох сэнс (FD fan)		TTL Eggn.	2025.07.16	2
Шахах сэнс (ID fan)		TTL Eggn.	2025.07.16	1
Газрын дээрх шугам хоолойн материалын тооцоо (MTO) – 2-р багц (AG Piping MTO- Lot 2)	CDU/VDU		2025.07.18	Lot 1
	Utilities			Lot 1
	Offsite			Lot 1
Ачихын автоматжуулалтын систем (Loading Automation System)		Adv.Sys	2025.08.20	1
Дулаан солилцуур (Heat Exchanger)		Precision Equipment	2025.08.23	15

ЕРС 02 багц ажлын хүрээнд нийт 1251 нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөгдсөнөөс 1083 нь худалдан авах захиалга (PO) хийгдсэн. Тоног төхөөрөмжийн худалдан авалт, захиалгын явц 86.6%-ийн гүйцэтгэлтэй байна.

Захиалга/худалдан авалтын биелэлт

№	Тоног төхөөрөмж төрөл	Процессын байгууламж		Хангамжийн байгууламж		Дагалдах байгууламж	
		Төлөвлөгөө, %	Бодит, %	Төлөвлөгөө, %	Бодит, %	Төлөвлөгөө, %	Бодит, %
1	Суурин тоног төхөөрөмж	23.0	22.7	9.0	8.9	23.0	22.6
2	Эргэлтэт тоног төхөөрөмж	19.0	18.1	23.0	21.8	19.0	18.5
3	Механик багц	14.0	13.4	14.0	12.8	9.0	8.1
4	Даралт сав, дулаан солилцуур, хадгалах сав	9.0	9.0	19.0	19.0	14.0	14.0
5	Шугам хоолой	12.0	10.1	12.0	10.1	12.0	10.1
6	Цахилгаан	7.0	2.4	7.0	2.5	7.0	2.6
7	Тоноглол	6.0	2.5	6.0	2.2	6.0	1.6
8	Төмөр хийц	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0
Нийт		100.0	87.8	100.0	87.4	100.0	87.3

Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл

ЕРС 02 багц ажлын хүрээнд хамрагдах тоног төхөөрөмжүүдийн үйлдвэрлэлийн (Mechanical design calculation, General arrangement drawing) механик дизайн тооцоолол, тоног төхөөрөмжийн загвар, зураг төсөл боловсруулах ажил II дахь шатандаа үргэлжилж байна.

Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчид ба ажлын явц-1

№	Нийлүүлэгч компани	Талбайд буух	Явц
1	Атмосферийн нэрлэгийн цамхаг (KCP, India)	2026.02.22	- CS, SS304L маркын гангаар үйлдвэрлэгдэж байна. - Нийт 48 метр нэрлэгийн цамхаг 21 үеэс бүрдэх ба их биеийг бүхэлд нь гагнаж дуусгасан ба үндсэн 5 дэд хэсэгт хуваан гагнуурын үзлэг шалгалт хийгдэж байгаа.

Үйлдвэрлэлийн зураг-1



KCP Company, Chennai, India

Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчид ба ажлын явц-2

№	Нийлүүлэгч компани	Талбайд буух	Явц
2	Вакум нэрлэгийн колонн (КСР)	2026.02.16	- CS, SS304L маркын гангууд үйлдвэрлэгчийн үйлдвэрт матаас, гагнаа ба доторлогоо зэрэг боловсруулалтад орж байгаа. - Нийт 46.8 метр нэрлэгийн цамхаг 17 үеээс бүрдэх ба их бие болон 11 үеийг тус бүрд гагнаж дуусгасан ба үндсэн гагнуурын үзлэг шалгалт хийгдэж байна. Үлдсэн үеүдэд маталт, давхарлагаа хийгдэж байгаа.

Үйлдвэрлэлийн зураг-2



Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчид ба ажлын явц-3, 4

№	Нийлүүлэгч компани	Талбайд буух	Явц
3	Зуух (Heurtey, France)	2026.04.07	Инженерчлэл: - Өгөгдлийн хуудас, GAD, P&ID, зуухны суурийн ажил дууссан. - 1-р шатны 3D моделийн хянах хурал 2025.01.30-31, HAZOP & SIL хурал 2025.02.27-28-нд зохион байгуулсан. Худалдан авалт: - Асаагуур, APH/SAPH, хөө үлээгч, конденсат хадгалах сав. Heurtey-ийн радиацийн ороомог ба конвекцийн модульд зориулж AS хоолой, цутгамал эд анги, холбох хэрэгсэл, фланцын захиалга өгсөн.
4	101-C-1002, 1003 102-C-1001-1007 цамхагууд (Sudhir brothers, India)	2026.04.08	- Гүйцэтгэл, ажлын ерөнхий зураг бүх нэрлэгийн цамхагт дууссан. - Бүх нэрлэгийн цамхгуудын ажилд шаардлагатай түүхий эд, материалыг татаж авсан байгаа. - Тус компани дээрх үлдсэн бүх нэрлэгийн цамхгийн механик угсралт гагнуурын ажил бүрэн эхэлсэн.

№	Нийлүүлэгч компани	Талбайд буух	Явц
5	Давсгүйжүүлэх төхөөрөмжийн доторх тоноглол (Forum USINC)	2025.12.06	Инженерчлэл: - PFD ба P&ID дууссан. Худалдан авалт: 242 тн хавтан төмөр 2024.12.31-нд хийгдсэн.
6	Хөргөлтийн цамхаг	2026.01.22	- Өгөгдлийн хуудас, GAD, P&ID, инженерчлэлийн ажил дууссан.
7	Ачих буулгах гар (Ferro tubes)		- Нийт 311 ачих буулгах гарт шаардагдах түүхий эд, материалын 50.0 хувийг цуглуулсан байгаа ба бензин ачих 102 гарын үйлдвэрлэл 2 сард, дизель ачих 102 гарын үйлдвэрлэл 2 сард, онгоцны түлш ачих 51 гарын үйлдвэрлэл 5 сард мөн пропан, бутан ачих 20 гарын үйлдвэрлэл 3 сард эхэлсэн.

Sparkle Clean Tech Pvt. Ltd компаниас ирүүлсэн үйлдвэрлэлийн зураг



1.2.4. БАРИЛГА УГСРАЛТ

ЕРС 02 багц ажлын барилга бүтээн байгуулалтын ажил үйлдвэрийн талбай дээр ид өрнөж байна. Үүнд технологийн үндсэн байгууламжуудын суурийн ажил, инженерийн шугам сүлжээ, ил болон далд шугам хоолой, шугам хоолойн эстакад, агуулах сав паркийн барилга угсралтын ажил болон даралтат савны үйлдэрлэл явагдаж байна. Зарим ажлаас дурдвал:

- Хийн түлш хадгалах хэвтээ даралтат сав: Бетон цутгалтын ажил дууссан.
- CRM-03 (Удирдлага, хяналтын барилга-03): Суурийн ханын цутгалтын ажил дууссан.
- Агуулах Сав-05: шугам хоолойн тулгуурын суурь цутгалтын ажил дууссан ба ханын бетон цутгалтын ажил хийгдэж байна.
- Хийн түлшний хэвтээ даралтат савыг суурилуулах байгууламжийн төмөр бетон хананы
- арматурын бэхэлгээ болон цутгалтын ажил хийгдэж байна.
- Бүх 35 ширхэг агуулах савны барилгын ажил дууссаж, механикийн ажил эхэлсэн.

- Үзлэгийн худаг: Нийт 347 үзлэгийн худгийн 222 угсармал бүтээцийг цутгаж, 222-ыг угсарсан. Угсармал бүтээцийн арматурчлал, хэв хашмалын ажил үргэлжилж байна.
- Хийн түлш хадгалах хэвтээ даралтат сав (нийт гангийн орц: 1985 тн): Хавтангийн тэмдэглэгээ болон зүсэлтийн ажил-1,490 тн, маталтын ажил-1460 тн, дагуу ширээс-1034 тн гүйцэтгэсэн.

Газрын тос хадгалах сав (45 000 м³)



Дагалдах, туслах, хангамжийн байгууламжийн шугам хоолойн эстакад



ШШХ буюу пропан, бутан хадгалах даралтат хэвтээ савны үйлдвэрлэл





1.3. ЕРС 03 БАГЦ АЖИЛ - Үйлдвэрийн Дулааны цахилгаан станц

ГТБҮ-ийн Дулааны цахилгаан станц (ДЦС)-ын үндсэн тоноглолд 19 МВт хүчин чадалтай 2 ширхэг турбингенератор, 280 т/ц уур боловсруулах хүчин чадалтай 2 ширхэг уурын генераторууд багтах бөгөөд нийт суурилагдсан хүчин чадал нь 38 МВт юм.

Станцын ажиллах зарчим нь боловсруулах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж байх үед уурын генераторууд нь бүрэн ачааллынхаа 50%-аас доош ачааллаар зэрэгцээ ажиллан уурын турбингенераторыг өндөр даралтын хурц уураар ханган цахилгаан болон дулааны эрчим хүчийг хослон үйлдвэрлэх бөгөөд аль нэг уурын генераторын ажиллагаа доголдох болон хамгаалалтаар зогсоход үлдсэн уурын генератор нь ачааллаа нэмэгдүүлэн боловсруулах үйлдвэрийн хурц уурын хэрэглээг бүрэн хангаж ажиллахаар төлөвлөгдсөн.


Уурын генераторын хувьд төлөвлөлт, инженерчлэл, хүчин чадлын баталгаа гаргагч буюу захиалагчаар Английн Woods компанийн харьяа Испанийн “FOSTER WHEELER/WOOD”, үйлдвэрлэл, угсралтын ажлуудыг БНЭУ-ын КСР компани ажиллаж байна. Уурын турбины төлөвлөлт болон үйлдвэрлэгчээр ХБНГУ улсын “SIEMENS” компанийн Энэтхэг дэх салбар ажиллаж байгаа бөгөөд ДЦС-ын 3D загварчлалыг боловсруулах ажлыг “MEIL” компани хийж гүйцэтгэж байна.

ГТБҮ-т ашиглагдах технологийн уурыг даралтын түвшний хувьд өндөр, дунд ба нам даралтын гэж ангилах бөгөөд доорх хэмжээний өндөр, дунд даралтын үйлдвэрийн уурыг боловсруулах үйлдвэрийн холбогдох технологийн байгууламжуудад нийлүүлнэ.

- Цагт 16.1 тонн хэмжээтэй 40 кг/см²г даралт, 485°С температуртай үйлдвэрийн уур (өндөр даралтын)
- Цагт 78 тонн хэмжээтэй 15 кг/см²г даралт, 305°С температуртай үйлдвэрийн уур (дунд даралтын)
- Цагт 8 тонн хэмжээтэй нам даралтын 5 кг/см²г даралттай, 160°С температуртай уурыг ДЦС-ын хэрэгцээнд ашиглана.

ДЦС-д үйлдвэрийн дагавар бүтээгдэхүүн болон зуухны шингэн түлшийг ашиглан дотоод хэрэгцээгээ эрчим хүчээр хангана.


ДЦС-ийн байрлал



1.3.1. ИНЖЕНЕРЧЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ БА 3D ЗАГВАРЧЛАЛ

ДЦС-ын 3D загварчлалын ажлыг MEIL компани хийж гүйцэтгэж байгаа бөгөөд загварчлалын 1-р шатны гүйцэтгэлийг хянах техникийн хурал 06 дугаар сарын 12-ноос 13-ны өдрүүдэд БНЭУ-д зохион байгуулагдсан. Энэ хурлаар ТМЗ компанийн хамт 3D загварчлалыг шалгаж, техникийн зургуудын бага хэмжээний зөрүүтэй байдлыг болон төлөвлөлтийн технологийн шийдлийг сайжруулах 164 санал, залруулга, тайлбарыг оруулж дараагийн онлайн хурлаар шийдвэрлэхээр болсон.

ДЦС-ийн 3D загварчлал




ДЦС-ын инженерчлэлийн бичиг баримт, тоноглолын хүснэгтийг гүйцэтгэгч компанийн зүгээс боловсруулан өөрийн цахим платформдоо байрлуулан түүн дээр ТМЗ компанийн болон манай байгууллагын инженерүүд хяналт тавин баталдаг бөгөөд энэ хугацаанд хянан шийдвэрлэсэн бичиг баримтуудаас дурдвал:

- B285-DAS-212-0009(Түлшний хадгалах савны (FO-1/FO2)(212-T-1021) Технологийн өгөгдлийн хүснэгт) шинэчилсэн хувилбар-4 танилцуулж код-2-оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0010 (Дезиль түлшний танк (FO3)(212-T-1022) Технологийн өгөгдлийн хүснэгт) шинэчилсэн хувилбар-4 танилцуулж код-2-оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0019(Үлээлгийн хөргүүрийн гадаргуу/бүрхүүл/ болон хоолойн Технологийн өгөгдлийн хүснэгт . (212-E1004 A/B),хувилбар 1-ийг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0021(Түлшний халаагчийн Технологийн өгөгдлийн хүснэгт (212-H-1004 A/B/C), хувилбар 2-ыг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0034(Түлшний насосын Технологийн өгөгдлийн хүснэгт 212-P-1018 A/B/C) хувилбар 3-ыг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0047 (Хурц уурын даралт бууруулагчын- HP-MP & MP-LP-212-LZ-1006 & 212-LZ-1007, Технологийн өгөгдлийн хүснэгт) хувилбар 2 танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0060(Шингэн түлшний цахилгаан халаагч 212-E-1002 C, Технологийн өгөгдлийн хүснэгт)хувилбар 0 танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0055(Зуухны тэжээлийн усны халаагчын Технологийн өгөгдлийн хүснэгт) хувилбар 1-ийг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0035(Дизель түлшний насосны 212-P-1019 A/B Технологийн өгөгдлийн хүснэгт) хувилбар 2-ыг танилцуулж код 2 оор баталгаажуулав.
- B285-DAS-212-0001(Үлээлгийн цуглуулагч хүлээн авах савны (212-V-1006 A/B),хувилбар 1-ийг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-PID-212-1044(Өндөр даралтын уурын турбин хөдөлгөгчтэй насосны шугам хоолойн диаграмм) хувилбар 1-ийг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-PID-212-1002(Уурын генераторын тэжээлийн усны насос болон тэжээлийн усны экспортын насосны шугам хоолойн диаграмм) хувилбар 3-ыг танилцуулж код 2 оор баталгаажуулав.
- B285-PID-212-1037(Дулааны цахилгаан станцын шугам хоолойн диаграммын хил хязгаарын зааг) хувилбар 3-ыг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-PID-212-1039(FO3 хадгалах сав болон Шингэн түлшийг оруулах дамжуулах үед халаах халаагчын шугам хоолойн диаграмм)хувилбар 4-ыг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-PID-212-1011(Уурын генераторын тунг тохируулагч /бодис/ шугам хоолойн диаграмм) хувилбар 3-ыг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-PID-212-1040(Бохир конденсацын системийн шугам хоолойн диаграмм) хувилбар 2-ыг танилцуулж код 2-оор баталгаажуулав.
- B285-PID-212-V003-0066(Уурын генераторын тортог үлээгчийн шугам хоолойн диаграмм) хувилбар 0-ийг танилцуулж код 2 оор баталгаажуулав.
- B285-PID-212-V003-0061(Уурын генератор-01 уур усны шугам хоолойн диаграмм) хувилбар 5-ыг танилцуулж код 2-оор баталгаажуулав.

1.2.3. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАТЕРИАЛЫН ХУДАЛДАН АВАЛТ, ЗАХИАЛГА

2025 оны III улирлын байдлаар доорх хүснэгтэд дурдсан тоноглолуудын захиалга хийгдэв. Тус тоног төхөөрөмжүүд 2026 оны эхний улиралд үйлдвэрээс гарч үйлдвэрийн талбай руу тээвэрлэгдэх болно.

ДЦС-ийн тоног төхөөрөмжүүд

№	Тоноглолын нэр	Үйлдвэрлэгч	Захиалга
1	Уурын генераторын яндан 	Isgec Heavy Engineering Ltd.	2025.02.04
2	Уурын генераторын цахилгаан үнс баригч 	Isgec Heavy Engineering Ltd.	2025.02.04
3	Азотын дутуу ислийг бууруулах төхөөрөмж 	KSB Limited	2025.01.10
4	Зуухны Үлээх салхилуур 	TLT Engineering India Pvt Ltd.	2025.06.16
5	Зуухны тэжээлийн усны насос 	KSB Limited	2025.06.16

1.3.2. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

Барилга угсралтын ажлын тоо хэмжээ, үйл явц

- **Уурын генераторын багц**
- Уурын тогооны үйлдвэрлэлийн ажил дуусаж бэлэн болсон бөгөөд будгийн ажил явагдаж байна.
- Даралтат савны үйлдвэрлэлтийн ажил КСР компанид явагдаж байна.
- Уурын генератор-1 болон 2-ын ууршуулагчын мушгиа хоолойнууд/ороомог/ бэлэн болсон.
- Уурын генератор-2 ууршуулагчын/84 ороомог/ мурийлтын ажиллагаа болон тулгалтын гагнуурын холболт ажил явагдаж байна.
- Экономайзер-Үйлдвэрлэлийн ажил явагдаж байна.
- Агаар халаагчийн үйлдвэрлэлийн ажил явагдаж байна.
- Анхдагч уур халаагчийн үйлдвэрлэлийн ажил явагдаж байна.
- Агаарыг уураар халаагчийн SS хоолой КСР дээр ирсэн бөгөөд түүхий материалыг тодорхойлсон.
- Асаагуурын ерөнхий зохион байгуулалтын шинэчлэгдсэн зураг болон технологийн өгөгдлийг хүснэгтийг үйлдвэрлэгчид танилцуулсан.
- Тортог үлээгчийн шинэчлэгдсэн технологийн өгөгдлийн хүснэгтийг үйлдвэрлэгчид танилцуулсан.
- ❖ **Уурын турбины багц**
- Турбины гол ажлын дугуй бэлэн болж SIEMENS дээр ирсэн.
- Турбины корпусын цутгалтын ажил хийгдэж байна.
- Цахилгаан генераторын захиалга хийгдсэн.
- Хурдны хайрцагын захиалга хийгдсэн.
- Тосолгооны системийн захиалга хийгдсэн.
- Уурын турбины конденсаторын жийргэвчний захиалга хийгдсэн.
- ❖ **Агаарын хөргөлттэй конденсаторын багц**
- Хоолойн багцын ажил дууссан.
- Сэнсний өгөгдлийн хүснэгт тодорхойлолтыг үйлдвэрлэгчээс ирүүлсэн.
- Мэдээллийн хүснэгтийг баталсны дараа үйлдвэрлэлийн зөвшөөрөл олгоно.
- ❖ **Деаэраторын багц**
- Үйлдвэрлэгчээс ирүүлсэн мэдээллийн хүснэгтийг шинэчилсэн.
- ❖ **Цахилгаан үнс баригчийн багц**
- Ерөнхий байгуулалтын зургийг Төслийн менежментийн зөвлөх код 2-оор баталгаажуулсан.
- Шугам хоолойн диаграмм Төслийн менежментийн зөвлөх код R -ээр баталгаажуулсан.
- Суурийн байгуулалтын зургийг код 2-оор баталгаажуулсан.
- Суурийн байгуулалтын тооцоог код R -ээр баталгаажуулсан.
- ❖ **De-NOx (SCR) багц**
- Шинэчлэгдсэн шугам хоолойн диаграмм болон технологийн өгөгдлийн хүснэгтийг үйлдвэрлэгчид танилцуулсан.
- ❖ **Уурын генераторын тэжээлийн усны насос**
- Төслийн менежментийн зөвлөхөөр шугам хоолойн диаграмм код 2 оор баталгаажуулсан.

ДЦС-ын Уурын генератор, Уурын турбингенератор зэрэг үндсэн технологийн, том оврын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчдийг сонгож, захиалгууд хийгдэн, үйлдвэрлэлийн ажил шат дараалалтай явагдаж байна. Үйлдвэрийн талбай дээр барилгын үндсэн бүтээцийн ажлын арматур, ган бүтээцийг хүлээн авч үндсэн тоноглолуудын суурь, дам нуруу, баганын бетон цутгалтын ажил болон Дэд станц-5 -ын өрлөгийн ажил явагдаж байна. Дараагийн

барилга угсралтын улиралд ган бүтээцийн ажлуудаас эхлэн барилга угсралтын ажил хийгдэх болно.


ДЦС-ийн Уурын генераторын яндангийн суурын ажил, Дэд станц-5-ын барилгын ажил Турбины болон Шугам хоолойн стакад хэв болон араматур цутгалтын ажил



1.4. ЕРС 04 БАГЦ АЖИЛ – Гүн боловсруулалтын Лицензтэй технологийн байгууламжууд

ЕРС 04 багц ажлын хүрээнд лицензтэй 7 технологийн байгууламж, дэд станц, удирдлага хяналтын барилгууд болон бусад дагалдах байгууламжууд баригдана. Лицензтэй байгууламжууд:

- Гидрокрекинг (UOP Honeywell, USA)
 - Устөрөгчийн үйлдвэр (Kinetics Technology, Italy)
 - Автобензин боловсруулалт (UOP Honeywell, USA)
 - Нафта гидроцэвэрлэгээ
 - Изомержуулах
 - Риформинг
 - Дизель гидроцэвэрлэгээ (UOP Honeywell, USA)
 - Шингэрүүлсэн шатдаг хий цэвэршүүлэх (UOP Honeywell, USA)
 - Висбрекинг (Shell, Netherlands)
 - Хүхэр ялгах байгууламжууд (Axens, France)
- Туслах байгууламжууд: Амин ялгах, Хүхэрлэг ус цэвэршүүлэх, Устөрөгч ялгах, түгээх байгууламжууд;
 - Эрчим хүчний, мониторинг хяналтын байгууламжууд: Дэд станц №2, 7; Удирдлага хяналтын барилга №1, 3;
 - Бусад: Катализатор болон химийн бодис хадгалах барилгууд



1.4.1. ИНЖЕНЕРЧЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨЛ БА 3D ЗАГВАРЧЛАЛ

ЕРС 04 багц ажлын явцыг эрчимжүүлэх зорилгоор захиалагчийн зүгээс хэд хэдэн инженерчлэлийн туслан гүйцэтгэгч компанийг зэрэг ажиллуулах шаардлага тавьж, ерөнхий гүйцэтгэгч Chemtex Global Engineers Pvt Ltd болон Intecsa Ingenieria Industrial компаниудыг сонгон, технологийн дараах байгууламжуудын инженерчлэлийн ажлуудыг хийлгэж байна. Үүнд:

Chemtex Global Engineers Pvt Ltd:

Байгууламжийн дугаар	Licensed Unit Name	Лицензтэй технологийн байгууламжууд	Тоног төхөөрөмжийн тоо
104	LPG Treating Unit (LPGTU)	ШШХ цэвэрлэгээний байгууламж	36
105	Naphtha Hydrotreating Unit (Part of MS Block)	Нафтагидро цэвэрлэгээний байгууламж (Бензин үйлдвэрлэх байгууламжийн нэг хэсэг)	57
106	ISOM	Изомержүүлэх байгууламж	45
107	SRR	Реформингийн байгууламж	70
108	HGU	Устөрөгчийн үйлдвэр	89
115	SRU, ARU, SWS	Хүхэр ялгах байгууламж	138
116	Hydrogen Compression & Distribution Unit (HCDU)	Устөрөгчийн цуглуулах, түгээх байгууламж	12

Intecsa Ingenieria Industrial:

Байгууламжийн дугаар	Licensed Unit Name	Лицензтэй технологийн байгууламжууд	тоног төхөөрөмжийн тоо хэмжээ
109	DHDT	Дизелийн гидроцэвэрлэгээ	88
110	HCU	Гидрокрекинг	201
111	VBU	Висбрекинг	133

Лицензтэй технологийн байгууламжуудын техникийн баримт бичиг

ЕРС 04 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгч болон инженерчлэлийн туслан гүйцэтгэгч компаниудаас дараах техникийн баримт бичгүүдийг хянуулах, батлуулахаар ирүүлээд байна. Ирүүлсэн техникийн баримт бичгүүд:

Устөрөгч үйлдвэрлэх байгууламжийн хувьд зарим тоног төхөөрөмжүүдийн өгөгдлийн хүснэгтийг боловсруулан ирүүлсэн. Үүнд:

- B285-EPR-DAS-108-0014-Устөрөгч үйлдвэрлэх байгууламжийн Реакторын өгөгдлийн хүснэгт;
- B285-EPR-DAS-108-0015-Устөрөгч үйлдвэрлэх байгууламжийн хүхэргүйжүүлэгч Реакторын өгөгдлийн хүснэгт;
- B285-EPR-DAS-108-0016-Устөрөгч үйлдвэрлэх байгууламжийн Реформерын реакторын өгөгдлийн хүснэгт;
- Автоматжуулалт, тоног төхөөрөмжийн тоноглолын схем зураг г.м.

Хүхэр ялгах байгууламжийн хувьд:

- Хүхэр ялгах байгууламжид Амин сэргээх болон Хүхэрлэг ус ялгах байгууламжууд мөн багтаж байгаатай холбоотой Хүхэр боловсруулах блок байгууламжуудын нэгдсэн дэвсгэр зураг (Plot plan) ирүүлсэн;
- Багцын бүх баримт бичгийг (төлөвлөлтийн зураг, техникийн үзүүлэлт, гарын авлага, нийлүүлэгчийн баримт гэх мэт) төвлөрсөн байдлаар бүртгэх, хянах зориулалттай мастер жагсаалт болох “Баримт бичгийн хяналтын индекс” (Document Control Index)-ийг Хүхрийн блок байгууламжид багтаж байгаа хэсэг тус бүрээр ирүүлсэн (Unit 112-Utilities, 113-SWS, 114-ARU, 115-SRU);
- B285-EPR-PID-115-1129 - Smartsulf реакторын шугам хоолойн тоноглолын диаграмм;
- B285-EPR-PID-115-1125 - Smartsulf реакторын шугам хоолойн тоноглолын диаграмм;
- B285-EPR-PID-115-1124 - 4 чиглэлтэй хавхлагуудын шугам хоолойн тоноглолын диаграмм;
- B285-EPR-PID-115-1123 - Эхний шатны дахин халаагчийн (reheater) шугам хоолойн тоноглолын диаграмм;
- B285-EPR-PID-115-1121 - (CLAUS) Агаар эргэлтийн тооцооллын шугам хоолойн тоноглолын диаграмм

ГТБҮ төслийн 4-р багц ажлын хүрээнд Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч болох Франц улсын Axens компанитай тоног төхөөрөмж (SmartSulf реактор+ 4 чиглэлт 6” хавхлагууд) нийлүүлэх гэрээ (№8433)-ний төслийг хэлэлцэх, өөрчлөлт оруулах онлайн хурлыг 2025 оны 09 дүгээр сарын 15,18-ны өдрүүдэд зохион байгуулсан ба техникийн талаас хянаж, санал өгч оролцов.

Лицензтэй технологийн байгууламжуудын 3D загварчлал

2025.09.03-нд Устөрөгч үйлдвэрлэх байгууламж (HGU), 09 дүгээр сарын 05-нд Хүхэр ялгах байгууламж (SRU)-ийн 3D загварчлалын 1-р шатны гүйцэтгэлийг тус тус ирүүлсэн бөгөөд нэгтгэсэн байдлаар HGU-S-BLOCK EPC04-EPC02 16.9.25.nwd файлыг 09 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авсан. 3D загварчлалын 1-р шатны гүйцэтгэл болон ерөнхий төлөвлөлтийг хэлэлцэх, техникийн хяналтын хурал уулзалтыг ТМЗ, ерөнхий гүйцэтгэгч MEIL, зураг төслийн туслан гүйцэтгэгч компани *CHEMTEX* болон Технологийн албаны инженерүүд хамтран 2025.09.16 ба 17-ны өдрүүдэд зохион байгуулж, дараах үндсэн асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Загварчлалын явц, хамрах хүрээ
2. Загварчлалын ерөнхий төлөвлөлт, координат болон стандарт мөрдөлт, гүйцэтгэлийн түвшин
3. Гол тоног төхөөрөмжүүдийн байршил, өндөрлөг ба байршлын түвшин, хошууны (nozzle) чиглэл, засвар үйлчилгээ хийх зай талбай
4. Гол шугам хоолойн маршрут, холболтын цэгүүд, тулгуурын зохион байгуулалт
5. Суурилуулалтын платформ, шат, гарцын зохион байгуулалт, суурь болон тоног төхөөрөмжийн холбоос
6. Цахилгаан, автоматжуулалт ба хэмжүүрийн систем, тоног төхөөрөмжийн байрлал, төрөл бүрийн кабелийн трасс
7. Загварын алдаа илрүүлэлт (Clash) – ноцтой, томоохон болон бага хэмжээний зөрчлүүдийн ангилал, шийдвэрлэх санал ба хариуцагч тал
8. Аюулгүй ажиллагаа ба засвар үйлчилгээ (HSE & Maintenance) – Аюулгүй ажиллагааны гарц, нүүлгэн шилжүүлэх боломж, техникийн ажиллагсдын нэвтрэх болон засвар үйлчилгээ хийх зай талбай
9. Санал, шүүмж (Punch-list) – илэрсэн асуудлууд, шийдвэрлэх арга зам, хугацаа болон хариуцлагын хуваарилалт
10. Дүгнэлт ба дараагийн алхам – Хурлаас гарсан шийдвэрүүд, дараагийн шатны бэлтгэл ажил.

3D загварчлалын 1-р шат (1-Хүхэр ялгах байгууламж, 2-Устөрөгч үйлдвэрдэх байгууламж)



1.4.2. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУДАЛДАН АВАЛТ, ЗАХИАЛГА БОЛОН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

III улиралд хийгдсэн лицензтэй технологийн байгууламжуудын тоног төхөөрөмжүүдийн захиалга:

№	Тоноглолын нэр	Үйлдвэрлэгч	Тоо хэмжээ, ш
1	Компрессор	Siemens	22
2	Процессын цамхагуудын дотор тоноглолууд	Sulzer болон Munters	23
3	Технологийн зуух	Heurtey	10
4	Процессын цамхагууд	Fabtech	23

EPC-04 багц ажилд хамрагдах дэд станц (SS-02, SS-07) болон удирдлагын барилгуудын (SRR-01, SRR-03) барилга угсралтын ажлын хувьд нийт 35,844 м³ газар шорооны ажил, 216 м³ ул бетон, 632 тн арматур, 4190 м³ төмөр бетон цутгалтын ажил, 14,234 м³ буцаан дүүргэлтийн ажлууд хийгдээд байна.

Цахилгааны дэд станц болон удирдлагын барилга



Нэмэлт мэдээлэл

ГТБҮ нь ТЭЗҮ-д тусгагдсан ерөнхий концепцийн дагуу баригдаж байгаа бөгөөд ТЭЗҮ-ийг БНЭУ-ын “Инженерс Индиа Лимитед” төрийн өмчит компани 2017 оны 09 дүгээр сараас эхлэн боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл 2018 оны 11 дүгээр сард хүлээн авч, 2019 оны эхээр эцэслэн баталгаажуулсан. Үйлдвэрийн НТЭЗҮ-ийг батлуулснаас хойш 5 жил тутамд тодотгох, шинэчлэх шаардлагын дагуу НТЭЗҮ-ийг боловсруулсан Инженерс Индиа Лимитед компани нь үйлдвэрийн технологийн зураг төсөл, техник технологийн нэмэлт өөрчлөлтүүд, цар тахалтай холбоотойгоор үүссэн дэлхийн зах зээл дээрх бараа материалын үнийн өсөлт зэрэг хүчин зүйлүүдийг авч үзэн, төслийн нийт хөрөнгө оруулалтын зардлын өөрчлөлтийг дахин тооцоолж, НТЭЗҮ-ийн тодотголыг УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар 2023 онд хэлэлцэн баталсан.

ХОЁР. ДАМЖУУЛАХ ХООЛОЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Дамжуулах хоолойн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит “Norinco International Cooperation” компани ажлаа эрчимтэй явуулж, өнөөдрийн байдлаар 515.0 км хоолойг гагнаж холбож, үл эвдэх радиограф, хэт авиа, соронзон бөөмийн сорилыг хийгээд байна. Хоолойн нарийвчилсан зураг төсөл, инженерчлэлийн ажлыг Канад улсын Worley Parsons компани гүйцэтгэж, Италийн Prometheus компани хяналт тавьсан. Өдөр тутмын хяналтыг төсөл хэрэгжүүлэгч МГТБҮ ХХК, Зохиогчийн хяналтын ажлыг Хятадын Sinopec компани, Захиалагчийн техникийн хяналтыг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ гүйцэтгэж байна.

МГТБҮ ХХК нь 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр төслийн талбайд өдөр тутмын хяналтыг 5 байршилд гүйцэтгэж байна.

Дамжуулах хоолойн барилга угсралтын ажил:

Шугам хоолойг сувгийн дагуу байрлуулах ажил Та-1 байгууламжийн холбох цэгт хүрсэн ба 527 км бүрэн дууссан. Terminal station-IHPS2 хүртэлх дамжуулах хоолойн гагнуур, үл эвдэх сорилын радиографик, хоолойн зэврэлтээс хамгаалах будаг, хоолойн ухмал, буцаан булалтын ажил хийгдэж дууссан бөгөөд IHPS2-Толгой станц хүртэлх хоолойн угсралтын ажил эрчимтэй явагдаж байна. Мөн дамжуулах хоолойн битүүмж, даралтын бат бэх шалгах усан тестийг (hydrostatic test) хэсэгчлэн хийж гүйцэтгэж байна.

- Хоолойн бат бэхийн тест: Ажлын даралтыг 1.1 дахин нэмэгдүүлж, 24 цагийн турш хянахад даралт унасан, хоолойн гагнуур задарсан, шүүрэлт гоожилт гарсан, битүүмж алдсан тохиолдол үүсээгүй болно.

Дамжуулах хоолойн бүх гагнуурын оёдлыг Үл эвдэх сорилын туршилтаар баталгаажуулж, хяналт тавин ажиллаж байна.

Халаах өргөх шахуургын станцуудын барилга угсралтын ажил:

Халаах, өргөх шахуургын станцуудын барилга угсралтын ажлын хувьд, ган бүтээцийн угсралтын ажил, барилгын суурийн буцаан дүүргэлт, нягтруулалт, сэндвичэн хавтан суурилуулах, станцуудын хоолойн холболт, барилгын суурийн өндөржилтийн хэмжилт болон ухмалын ажил, хэв хашмал, арматурчлалын ажил, хөнгөн блокийн өрлөгийн ажлууд хийгдэж байна.

- Ус цэвэршүүлэх барилгын цэвэр усны хоолойн угсралт, гагнуурын ажил
- Гадна шугам хоолойн угсралт, тулгуур ба ган бүтээцийн ажлууд
- Нүүрсний агуулахын барилгын газар шорооны буцаан булалт
- Авто засварын төвийн барилгын дээвэр, гадна фасад, профиль төмөр рампын ажил
- Насос станцын барилгын ханын чулуун хөвөн дулаалгын ажил
- Уурын зуухны барилгын метал хийцийн боолт чангалгааны ажил
- Инженерийн шугам сүлжээний хоолойн гагнуурын ажил
- Оффисын барилгын дээврийн хоёрдугаар үеийн мембран наалт
- Гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил
- Гадна дулааны шугамын гагнуур, залгаасын 2 үе хамгаалалтын будгийн ажил
- Цэвэр усны шугамын гагнуурын ажил
- Гүний худгуудын барилга угсралт
- Насос станцын шугам хоолойн хаалт хавхлагууд, фланц, отвод, тройник зэрэг эргэлтийн бэлдэцүүдийг холбох гагнуурын ажил
- Цэвэр усны шугамын богино холболтуудын паск гаргах, залгаасны гагнуурын ажлууд тус тус хийгдэж байна.

Газрын тос хадгалах савны барилга угсралтын ажил:

Толгой станцын тус бүр нь 10,000 м3 эзэлхүүнтэй 4 ширхэг савны үндсэн бүтээцийн ажил дуусч, савны тоноглолуудыг суурилуулах ажил хийгдэж байна.

ЦДАШ, дэд станцын барилга угсралтын ажил:

ЦДАШ-ын ажил бүрэн дуусч, 2-р станц дээр баригдаж байгаа 110/35/10 кВА-ын дэд станцын барилга угсралтын ажил хийгдэж байна. Мөн Тосон-Уул 19-р талбайд баригдах 110/10 кВА-ын дэд станцын зураг төслийн ажил хийгдэж байна.


Ажлын гүйцэтгэлийн хүснэгт

Д/д	Тайлбар	Үндсэн үзүүлэлт	7 сар хүртэл хуримтлагдсан	8 сар хүртэл хуримтлагдсан	9 сар хүртэл хуримтлагдсан
1	Инженерчлэл	4.30%	93.90%	93.90%	93.90%
2	Худалдан авалт	42.50%	97.40%	97.40%	97.40%
3	Барилга угсралт	53.20%	76.90%	80.50%	82.50%
Нийт		100%	86.40%	88.30%	89.40%

Барилга угсралтын ажил

1.	Дамжуулах хоолойн барилга угсралтын ажил	97%
1.1	Шугам хоолойг сувгийн дагуу байрлуулах ажил	Нийт- 526 км
1.2	Хоолойн гагнуурын ажил	Нийт- 521 км
1.3	Үл эвдэх сорилын радиографийн арга	Нийт- 520 км
1.4	Зэврэлтээс хамгаалах будгийн ажил	Нийт- 519 км
1.5	Тусгаарлагч /Дулаалгын ажил	Нийт- 519 км
1.6	Дулаалга хөөсний ажил	Нийт- 519 км
1.7	Дамжуулах хоолойн ухмалын ажил	Нийт- 520 км
1.8	Дамжуулах хоолой буулгах ажил	Нийт- 519 км
1.9	Дамжуулах хоолой булах ажил	Нийт- 512 км
1.10	Дамжуулах хоолойн усан шахалтын тест	Нийт- 436 км
2.	Станцын барилга угсралтын ажил	24%
2.1	Толгой станцийн барилга байгууламж	22%
2.2	Дундын IHPS1 барилга байгууламж	20%
2.3	Дундын IHPS2 барилга байгууламж	42%
2.4	Дундын IHPS3 барилга байгууламж	19%
2.5	Дундын IHPS4 барилга байгууламж	38%
2.6	Хүлээн авах станц	-
2.7	Хаалт хавхлагын станц	-
3.	ЦДАШ-ын барилга угсралтын ажил	98%


Барилга угсралтын ажлын явцаас



ГУРАВ. ГАЗРЫН ТОСНЫ ҮЙЛДВЭРИЙН ХОТХОНЫ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Хотхоны бүтээн байгуулалтыг 2 хэсэгт хуваан хэрэгжүүлж байгаа бөгөөд I ээлжийн барилга угсралт (4 орон сууцны барилга, Оффис үйлчилгээний төв), II ээлжийн барилга угсралт (6 орон сууцны барилга)-аас бүрдэж байна.

Хотхоны ерөнхий зураг



Хотхоны I ээлжийн барилгуудаас 3 объектын барилгын ажил дуусч, ашиглалтад оруулаад байна.

Ажлын гүйцэтгэл

№	Гүйцэтгэгч	Объект	Гүйцэтгэл	Статус
1	"Хангай бигэр" ХХК	40-4	100%	2022.08 сард байнгын ашиглалтад орсон.
		95-1	100%	2025.02 сард байнгын ашиглалтад орсон.
		Оффис үйлчилгээний төв	100%	2025.07 сард байнгын ашиглалтад орсон.
2	"Тобэм" ХХК	95-2	78%	Барилгын ажил удаашралтай.
		32-9	58%	

Оффис-үйлчилгээний төв



Хотхоны II ээлжийн барилга угсралтын ажлыг Батлан хамгаалах яам (БХЯ), Зэвсэгт хүчний 339-р анги хариуцаж байгаа бөгөөд ажлаа 2021 оны 7-р сараас хойш зогсоож, төсвийг их хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлага тавьж өнөөг хүрсэн. Асуудлыг шийдвэрлэхээр МГТБҮ ТӨХХК-ийн зүгээс сайд нарын түвшинд болон холбогдох байгууллагуудын оролцоотойгоор 4 жилийн турш уулзалт хэлэлцээ хийж, төр засгийн түвшинд (үүний дотор ҮАБЗ-д) удаа дараа танилцуулж, гэрээний үүргийг биелүүлэхийг шаардсан олон тооны албан бичгүүдийг БХЯ, Зэвсэгт хүчний 339-р хүргүүлэн ажиллаж байна. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд БХЯ болон Зэвсэгт хүчний 339-р анги “Баянтосон” ХХК-тай байгуулсан гэрээгээ сунгаж, 95-3 орон сууцны барилга угсралтын ажил үргэлжилж байна.

Ажлын гүйцэтгэл

№	Гүйцэтгэгч	Орон сууц	Гүйцэтгэл	Статус
1	“Баян Тосон” ХХК	95-3	46%	2024 оноос ажлаа үргэлжлүүлж байна.
2	“Баярс Констракшн” ХХК	40-8	30%	Ажил 2021 оны 7-р сард зогссон.
		40-7	30%	
		32-10	30%	
3	“Их даян бүүвэй” ХХК	40-6	34%	Ажил 2021 оны 7-р сард зогссон.
		40-5	15%	

II ээлжийн объектууд



Хотхоны бүтээн байгуулалтын ажлын зардлыг Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх Засгийн газрын 2019 оны 129-р тогтоол хүчин төгөлдөр байгаа хэдий ч хотхоны 2-р ээлжийн барилгуудын санхүүжилтийг шийдвэрлэх эсэх нь тодорхойгүй хэвээр байна.

ДӨРӨВ. ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ АШИГЛАЛТ

ГТБҮ-ийн бүтээн байгуулалтын ажил эрчимжин, үйлдвэр ашиглалтад орох хугацаа ойртож байгаа энэ үед үйлдвэрийн түүхий эдийн хангамж нэн тулгамдсан асуудал болоод байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн “стратегийн ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах” тухай 2014 оны 14/06 дугаар зөвлөмжийн дагуу ГТБҮ-ийг Тамсагийн сав газарт БНХАУ-ын “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн олборлолт явуулж буй XIX, XXI талбайн Газрын тосны шинж чанар, тус компанийн 2011-2012 онд батлуулсан “Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд үндэслэн төлөвлөсөн болно. Нөөцийг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн захиалгаар АНУ-ын DeGolyer & MacNaughton компани 2010-2011 онд тооцсон байна.

“Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд 2020 онд газрын тосны олборлолтыг жилд 1.5 сая тоннд хүргэж, цаашид 20-иод энэ хэмжээнд байхаар заасан хэдий ч 2016 онд 1,2 сая тоннд хүргэж байсан олборлолтын хэмжээгээ сүүлийн жилүүдэд тогтмол бууруулсаар ирэх оны олборлолтын төлөвлөгөөгөө 350.000 тонн байхаар төлөвлөж АМГТГ-т хүргүүлсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч компанийн зүгээс түүхий эдийн хангамжийн талаар 2020 оноос эхлэн холбогдох төр засгийн байгууллагуудад удаа дараа хандаж ирсэн бөгөөд уг асуудлаар УИХ, Засгийн газар, Шадар сайдын зүгээс салбарын яам, агентлагт хэд хэдэн удаа үүрэг чиглэлийг өгч байсан хэдий ч олборлолтын хэмжээ нэмэгдээгүй хэвээр байна.

МГТБҮ нь Давст XXXI талбайд газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахын тулд бүхий л арга хэмжээг авч, сүүлийн 3 жилийн хугацаанд геологи, геофизикийн тайлал, газрын тосны мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байгаагийн зэрэгцээ хөрөнгө оруулалт татах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Давст XXXI талбайн хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны чиглэлээр

- МГТБҮ ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, ГТХАГ-ын дарга Д.Буян-Аривжих нар “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Дачин Ченпин” компанийн удирдлагуудтай 2025.07 сард уулзалт хийж, Давст XXXI талбайд өрөмдсөн тосны бага гарцтай цооногт “Дачин Ченпин” компаниар дараа төлбөрт нөхцөлөөр USD өрөмдлөг болон шингэн хагалбарын ажил хийлгэх, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-иар цооногийг тоноглуулж, улмаар газрын тосны олборлолтын үйл ажиллагааг явуулах талаар яриа хэлэлцээ хийсэн.

Хэлэлцээрийн гол зорилго нь “Дачин Ченпин” компанийн ажил гүйцэтгэх үнийн санал нь “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Дачин Ченпин” компаниудын хооронд байгуулсан гэрээнд тусгасан үнээс өндөр байсан учир тухайн үнийг буулгахад чиглэсэн.



Гэвч тухайн хэлэлцээр, үүнийг дагаж харилцсан олон хэлбэрийн уулзалтууд зорилтот үр дүнд хүрч чадаагүй. “Дачин Ченпин” компани нь үнийг 6 сард буулгасан хэмжээнээс дахин багасгахгүй гэсэн хатуу байр суурьтай байв. Тэд үүнийг “ихэнх ажил үйлчилгээ, материалын захиалга, татан авалт, цооногийг бэлтгэх ажлыг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн өөрийнх нь оролцоотой хийдэг, мөн энэ үйлчилгээг олон тооны цооногт хийх тохиролцоотой учир үнийн саналд ийм их ялгаа байгаа юм” хэмээн тайлбарласан бөгөөд МГТБҮ нь үнийн санал дээр дүгнэлт гаргуулахаар чиглэлийн яаманд хандсан боловч энэ талаар бидэнд хариу ирүүлээгүй болно.

- МГТБҮ ХХК-ийн ГТХАГ, Гэрээ эрх зүйн газрын мэргэжилтнүүд хамтран “Дачин Ченпин” компаниар USD хэвтээ өрөмдлөг болон шингэн хагалбарын ажлыг Давст ХХХI талбайд гүйцэтгүүлэх “Гэрээний төслийг” боловсруулсан. Гэрээний төсөлд санал авах зорилгоор АҮЭБЯ-нд илгээсэн. Улмаар гэрээний төсөл дээр АМГТГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж зарим засвар, өөрчлөлтүүдийг хийсэн. Харамсалтай нь Давст ХХХI талбайд өрөмдсөн тосны бага гарцтай хуучин цооногт дараа төлбөрт нөхцлөөр “Дачин Ченпин” компаниар USD өрөмдлөг, шингэн хагалбар хийлгэх, улмаар тухайн цооногийг тоноглох, тосны олборлолт хийх, Газрын тосыг ус болон, механик хольцоос нь салгаж цэвэрлэх, тээвэрлэх, борлуулах ажлыг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-иар хийлгэх ажлыг АҮЭБЯ-наас дэмжээгүй учир энэ ажил зогссон. АҮЭБЯ-наас өрөмдлөгийн улирал дуусах хүртэл ганцхан цооногт ийм ажил хийх боломжтой бага хугацаа үлдсэн байсан үед энэ ажлыг өөрийн ТУЗ болон толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-иар шийдвэрлүүлэхийг үүрэг болгосон.
- АНУ-ын Alborgin&Co компаниас Давст ХХХI талбайд хамтран ажиллахыг сонирхож байгаагаа илэрхийлсэн. Тус компанитай “нууц үл задруулах” гэрээ байгуулж, долоо хоногийн Пүрэв гариг бүрт видео хурал зохион байгуулж техник, эдийн засгийн олон асуудлуудаар илтгэл тавьж, санал солилцож, мэдээлэл илгээж байна.



- Газрын тосны өрөмдлөг болон бусад үйлчилгээ үзүүлдэг DQE компанийн удирдлагатай уулзаж тус компанийн 05-р сард МГТБҮ-т ирүүлсэн өрөм болон бусад үйлчилгээний үнийн санал дээр дахин ярилцсан. Тэдний зүгээс үнийн санал дахин ирүүлсэн боловч анхны үнийн саналаас нэг их өөрчлөгдөөгүй. Тус компанийн зүгээс “ажил үйлчилгээний үнэ нь толгой компанид тарифын системд орсон учир үнэ бууруулахад DQE компанийн удирдлагуудын эрх мэдэл хүрэхгүй болсон” хэмээн тайлбарласан. Үнийн саналд байгаа хамгийн төвөгтэй асуудал бол өрмийн цамхагийг талбайд авчрах, мөн татан буулгах, цооног хооронд нүүлгэх зардал өндөр байгаа явдал юм. Тухайн компаниас “3000 метр хүртэл өрөмдөх чадалтай Derrick-ийг тээвэрлэхэд 70 орчим хүнд даацын ачааны машин үйл ажиллагаанд оролцдог. Гэвч ийм тооны ачааны машин талбай дээр байхгүй. Бид эдгээр машинуудыг Улаанбаатар хот болон бусад газраас цуглуулж талбайд авчирдаг учир тээврийн зардал өндөр байхаас аргагүй” гэж тайлбарлаж байна. Түүнчлэн DQE компани нь Давст ХХХI талбайд 2026 онд тус компаниар хайгуулын цооног өрөмдүүлэх төлөвлөгөөтэй байгаа бол 2025 онд багтаж “үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулах шаардлагатай болохыг мэдэгдсэн.

Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай холбоотой ажлууд

- Давст ХХХI талбайн геологи, геофизикийн судалгааны ажлын өгөгдлүүдэд тайлал хийх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.
- Тодорхойлсон проспектуудаас өрөмдөхөд бэлэн 3 проспектийг сонгон ойр зэргэлдээ өрөмдсөн цооногуудын өгөгдлүүдтэй харьцуулах замаар тэдгээрийн геологийн эрсдэлийг багасгах ажил хийгдэж байна.
- Давст ХХХI талбайд газрын тосны хуримтлал агуулж болох проспект, лийдүүдийг хайж тодорхойлох ажил үргэлжилж байна.
- “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн геологичид манай байгууллага дээр ирж сейсмийн тайллын ажил дээр санал бодлоо солилцсон.
- Цооногийн өрөмдлөгийн үйлчилгээ явуулдаг БНХАУ-ын “DQE” компанитай уулзаж өрөмдлөгийн ажлын үнийн саналыг авсан.
- Давст ХХХI талбайд албан томилолтоор ажиллан хээрийн судалгааны ажил гүйцэтгэж, тус талбайд урьд онуудад өрөмдсөн хайгуулын цооногуудын өнөөгийн нөхцөл байдлыг фото зургаар баримтжуулсан. Хээрийн судалгааны явцад зарим цооногийн амсраас тос нэвчиж гарсныг тогтоосон.
- Тосон-Уул XIX талбай дээр “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн захиалгаар “Дачин Ченпин” компанийн хэрэгжүүлж байгаа “USR хэвтээ өрөмдлөгийн” ажил болон ашигладаг тоног төхөөрөмжтэй танилцсан.
- АМГТГ-ын дээж хадгалах агуулахад ажиллаж 21-33, 21-40 цооногуудын чөмөг дээжийн зураглалыг хийсэн.
- Mining week 2025 Олон улсын Уул уурхайн чуулга уулзалтад оролцож, компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан.

ТАВ.ҮЙЛДВЭРИЙН ГАДНАХ ДЭД БҮТЦИЙН ТАЛААР

Авто зам: ГТБҮ-ийг Сайншанд хоттой холбох 17.5 км авто зам”-ын авто замын арчлалт, ашиглалтыг “Дорноговь АЗЗА” ТӨХК хариуцан ажиллаж байна.

Үйлдвэрийн гадна авто зогсоол, салаа авто замд технологийн болон технологийн бус гэмтэл, хагарал үүссэнийг засварлах ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. Мөн үйлдвэрийн талбай доторх 17 км асфальтан авто замын ашиглалт, арчлалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

Төмөр зам: Үйлдвэрийг Сайншанд хоттой холбосон төмөр замын арчлалт, хамгаалалтыг “Монголиан транс ложистик” (МТЛ) ХХК хариуцан ажиллаж байгаа бөгөөд тус компани нь галт тэрэгний хөдөлгөөний байнгын бэлэн байдлыг хангаж, шаардлагатай завсар үйлчилгээний ажлуудыг хийж ирсэн. Төмөр замын арчлалт, хамгаалалтын ажлын гүйцэтгэгч МТЛ ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дуусч, МГТБҮ ХХК-иас 3 удаагийн тендер зарласан боловч нэг ч компани оролцоогүй тул МТЛ ХХК нь үргэлжлүүлэн галт тэрэгний байнгын хөдөлгөөнийг ханган төмөр замын арчлалт хамгаалалтыг хийж гүйцэтгэж байна. МГТБҮ ХХК-иас төмөр замын арчлалт, хамгаалалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2025.09 сард дахин зарлаад байна.

Төмөр замын арчлалт хамгаалалтын үйл явц



Төмөр замын далан



Төмөр замын ухмалын хэсэгт далангийн хажуу налуу борооны усанд урссан. Энэ ухмалын доторх төмөр замын хэсэгт шороогоор дарагдаж байгаа тул хамгаалах үерийн ус зайлуулах шуудууг сэргээх шаардлагатай. Ухмалын дээд ба дотор талд шуудуу сэргээх ажлын тендерийн бэлтгэл ажил хийгдэж байна.

ЗУРГАА. ГЭРЭЭ, ЭРХЗҮЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

ТМЗ-өөр ажиллаж буй EIL компани болон EPC 01 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгч KPIL, EPC 02, 03, 04 багц ажлуудын Ерөнхий гүйцэтгэгч MEIL компанийн инженер, техникийн ажиллагсадтай өдөр тутмын болон өргөтгөсөн хурал уулзалтуудыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулах, инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

МГТБҮ ХХК нь тайлант хугацаанд дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудтай бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон бусад чиглэлээр 10 гэрээ байгуулан ажилласан. Мөн 8 гэрээг дүгнэж, дуусгавар болгосон. Үүнд:

- Үйлдвэрийн талбай, авто зам, төмөр зам, ус дамжуулах шугам хоолойн нутаг дэвсгэрт орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн тайлан боловсруулах ажлын гэрээг 2025.07.01-ний өдөр “Форэст экологи Лааят” ХХК-тай байгуулсан.

- Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд гадаад, дотоодын зочид төлөөлөгч нартай хийх уулзалтад зориулан Катерингийн үйлчилгээ үзүүлэх гэрээг 2025.07.07-ны өдөр байгуулж, гэрээг 2025.07.21-ний өдөр дүгнэж акт үйлдэв.
- “Газрын тос дамжуулах хоолойн барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналтын үйлчилгээ үзүүлэх” гэрээг “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай 2025.07.25-ны өдөр байгуулсан.
- “Газрын тос боловсруулах үйлдвэрийн дулааны цахилгаан станц”-ын зураг төсөл, барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналтын үйлчилгээ үзүүлэх гэрээг “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-тай 2025.08.11-ний өдөр байгуулсан.
- “Даатгалын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г “Бодь даатгал” ХК-тай 2025.08.11-ний өдөр байгуулсан.
- Компанийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахаар Серверийн хамгаалалтын программ (Firewall) нийлүүлэх гэрээг “Мобинет” ХХК-тай 2025.08.21-ний өдөр байгуулсан.
- Компанийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахаар Серверийн хамгаалалтын программ (Kaspersky) нийлүүлэх гэрээг “Мобинет” ХХК-тай 2025.08.21-ний өдөр байгуулсан.
- “Хангай бигэр” ХХК-тай 2019.08.23-ны өдөр байгуулсан “Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийн хотхоны 1-р шатны оффис үйлчилгээ, 95 айлын орон сууц болон 40 айлын орон сууцны барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу барилгын ажил дуусгаж, байнгын ашиглалтад оруулсан тул 2025.08.20-ны өдөр гэрээг дүгнэж акт үйлдэв.
- “Бодь даатгал” ХК-тай байгуулсан Орон сууц эзэмшигчийн иж бүрэн даатгалын гэрээ, Ажил олгогчийн хариуцлагын даатгалын гэрээг 2025.08.25-ны өдөр тус тус дүгнэж, акт үйлдэв.
- Үйлдвэрийн ашиглалтад орсон зарим барилгыг цахилгаан эрчим хүчээр хангахаар “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-тай “Цахилгаан эрчим хүчээр хангах” гэрээг 2025.09.02-ны өдөр байгуулсан.
- “Төгрөг баян хангай” ХХК-тай 2025.09.05-ны өдөр “Үйлдвэрийн ДЦС-ын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” боловсруулах үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан.
- “Анар-Орших” ХХК-тай байгуулсан Худалдах, худалдан авах гэрээний дагуу 4 дугуйт мотоциклийг хүлээн авч 2025.09.18-ны өдөр гэрээг дүгнэн акт үйлдэв.

Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: МГТБҮ ХХК-ийн 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу бусад аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээ хэлцэлд авлигын эсрэг зүйл заалтыг оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Маргаан, зөрчил, гомдол, тэдгээрийн шийдвэрлэсэн байдлын хувьд: Тайлант хугацаанд компанийн удирдлага, захиргааны албанд хандаж гаргасан маргаан, зөрчил, гомдол байхгүй байна.

ДОЛОО. ХУДАЛДАН АВАЛТ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувьд:

2025 онд барилга, байгууламж, авто тээврийн хэрэгсэл, компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга, аж ахуйн эд хогшил, их засварын ажил, ТЭЗҮ, зураг төслийн ажилд 8,9 тэрбум төгрөгийн төсвийг баталснаас 7,1 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй худалдан авалтын гэрээ байгуулан ажилласан. Барилга байгууламжаас бусад хөрөнгө оруулалтын хувьд 2025 оны 03 дугаар улирлын байдлаар нийт 7 гэрээг байгуулсан бол урсгал шинжтэй бараа материалын худалдан авалтад 17 гэрээг байгуулж, үнийн дүнгийн хувьд 81 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.

Бараа материалын худалдан авалт, тендер шалгаруулалтын арга, байгуулсан гэрээний дүн, тоо

№	Тендер шалгаруулалтын арга	Төсөл, арга хэмжээний тоо, ш	Төсөвт өртөг, сая ₮	Гэрээ байгуулсан, худалдан авсан дүн, сая ₮	Гэрээ байгуулсан тоо, ш
1	Нээлттэй тендер шалгаруулалт	8	8,154.2	6,876.2	3
2	Харьцуулалтын арга	11	499.3	147.92	4
3	Шууд худалдан авалт	24	216.97	125.2	17
	Нийт:	43	8,870.5	7,149.3	24

Санхүүжилтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байдлын хувьд:

МГТБҮ ХХК-ийн нийт зардал 2025 оны 03 дугаар улиралд төлөвлөснөөс 75,575.18 сая төгрөгөөр хэтэрсэн гүйцэтгэлтэй гарахад ГТҮ-ийн ажил эрчимжиж ажилчид 14 хоногоор ээлжээр томилолтоор явж ажилласан, дамжуулах хоолойн албаны томилолтын зардлыг дотоод томилолтын зардлаас хасаж тодотгол баталсан зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Төслийн батлагдсан төсөв, календарчилсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж буй байдлын хувьд:

2025 оны 09 дугаар сарын 30-ны байдлаар БНЭУ-ын Экспорт-Импортын банкны хөнгөлөлттэй зээлийн нийт санхүүжилт болох 1,698.2 сая ам.долларын 19.0 хувь буюу 328.3 сая ам.долларыг календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг санхүүжүүлэхэд зарцуулаад байна.

Хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлын хувьд:

ГТБҮ байгуулах төслийг бүрэн хэрэгжүүлж, үйлдвэрийг ашиглалтад оруулахад нэмэлт санхүүжилт шаардлагатай болсон учраас төслийг хэрэгжүүлэгч компани, хоёр улсын Засгийн газар хоёрын хооронд 2 жил орчим хугацаанд яриа хэлэлцээ хийсний эцэст 2024 оны 11 дүгээр сард БНЭУ-ын Засгийн газраас нэмэлт санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. Улсын Их Хурал 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр уг шийдвэрийг баталснаар төслийн санхүүжилтийн асуудал бүрэн шийдэгдсэн. Үүний дагуу 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр МГТБҮ ХХК, БНЭУ-ын “Megha Engineering and Infrastructures Limited” компани хооронд үйлдвэрийн суурийн бүтээн байгуулалтын EPC 04 багц ажлын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын гэрээ байгуулагдсан.

Түүнчлэн “Даян дээрхи энерги” ХХК-ийн зуучлалаар Сингапур улсын “Mercom Offshore & Marine Pte Ltd” (Mercom)-д Давст XXXI талбайд явуулах газрын тосны хайгуул, ашиглалтын

үйл ажиллагаанд хөрөнгө оруулах сонирхлыг нь татах зорилгоор тус талбайн талаар техникийн илтгэл тавьж, улмаар Давст ХХХI талбайн мэдээллийн сантай танилцах “үл задруулах” гэрээг тус компанитай байгуулсан.

Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үнэлгээний хувьд:

2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт хүргүүлэхээр заасан нийт 11 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллав. Түүнчлэн, 2025 оны 09 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлэх 7 зөвлөмжийн биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв. Үлдсэн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор бүрэн хэрэгжүүлсэн.

Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн биелэлт

№	Акт, албан шаардлага, зөвлөмж	Акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал	Биелэлт ирүүлэх огноо
1	Худалдан авсан хөрөнгө материалын нягтлан бодох бүртгэлийн бүртгэсэн дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнгээс 20 иргэн, байгууллага 159.5 сая төгрөгөөр дутуу, 168 иргэн байгууллага 91,197.5 сая төгрөгийг илүү бүртгэсэн байна.	Төлбөрийн баримтын цахим системд харилцагч байгууллагуудын и-баримтыг шивүүлэх, журналын гүйлгээтэй тогтмол тулган баталгаажуулан ажиллаж байна.	2025.09.01
2	МГТБҮ ТӨХХК-ийн захирлын "Захиргааны орон тооны бүтцийг батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан Компанийн бүтэц орон тооны жагсаалтад ерөнхий нягтлан бодогчийн орон тоог батлаагүй байна.	Гүйцтэх захирлын 2025.01.02-ны өдрийн А/01 тоот Захиргааны орон тооны бүтэц батлах тухай тушаалаар Ерөнхий нягтлан бодогчийн орон тоог батлуулсан. Сонгон шалгаруулалт зарлан, ажилд авахаар ажиллаж байна.	2025.09.01
3	Шалгагдагч байгууллага нь нийт 6 байгууллагын нийт 231.3 сая төгрөгийн өр төлбөр, 12 байгууллагын нийт 336.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Байгууллагуудтай өглөг, авлагын үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.	2025.09.01
4	Шалгагдагч байгууллага нь 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан жилийн 337.6 сая төгрөгийн дүнтэй 23/09;23/23-МГТБҮ тоот гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А-1/893 тоот албан бичгээр Ажлын байр түрээслэх зөвшөөрөл олгосон боловч тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан байна.	2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Ажлын байр түрээслэх асуудлыг тусган батлуулсан. Худалдан авах ажиллагааны тендерийг зарлаж 2025.05.01-ээс гэрээ байгуулсан.	2025.09.01

5	Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 157 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 149, хугацаа хоцорч мэдээлсэн 6, хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна. Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод, хугацаанд нь байршуулж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	Шилэн дансны мэдээлэл байршуулах төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлаар батлуулан, ажиллаж байна.	2025.09.01
6	Монгол Газрын тос боловсруулах үйлдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлах тухай 4 дүгээр тогтоолд 2024 оны нийт зардлыг 8,578.3 сая төгрөгөөр баталснаас 12,298.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу нийт зардлын төлөвлөгөөг /элэгдлийн зардлаар/ 3,312.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.	Компанийн Зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, зардлын төсөв, төлөвлөгөөнд тодотгол оруулан, батлуулан ажиллаж байна.	2025.09.01
7	Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээгүй 2 ААН-д нийт 17.5 сая төгрөгийг шилжүүлж, сургалтын зардлаар бүртгэж тайлагнасан байна.	2 байгууллагатай сургалтын гэрээ, гэрээ дүгнэсэн актыг үйлдэж баталгаажуулсан.	2025.09.01

НАЙМ. БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

ГТБҮ байгуулах төсөл нь Дорноговь аймгийн Алтанширээ суманд, Газрын тосны үйлдвэрийн хотхон Дорноговь аймгийн Сайншанд сум, Газрын тос дамжуулах хоолой барих төсөл нь Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн 8 сум, нийт 3 аймгийн 10 сумын нутаг дэвсгэрийг хамран хэрэгжиж байна.

ГТБҮ байгуулах болон бусад төслүүд хэрэгжиж эхэлсэн цагаас МГТБҮ ХХК нь дээрх аймаг, сумдын удирдлагууд, төрийн албан хаагчид, иргэд, олон нийттэй боломжит бүхий л чиглэлд ойлголцон хамтран ажилласаар ирсэн. Төслийн хэрэгжилт, бүтээн байгуулалтууд нь орон нутгийн үйлдвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагаа, ажлын байр, иргэдийн аж амьдралд шууд болон дам байдлаар эерэг нөлөөлөл үзүүлж байна.

Тухайлбал, ГТБҮ, дамжуулах хоолой, хотхоны бүтээн байгуулалтын ажилд туслан гүйцэтгэгчээр болон бараа бүтээгдэхүүн, материалын тээвэрлэлтэд орон нутгийн 40 орчим компани оролцон ажиллаж байна. Түүнээс гадна бүтээн байгуулалтад оролцож буй дотоод, гадаадын нийт 4000 орчим ажилтнуудын хоол хүнсний хангамжийн зарим хэсгийг орон нутгийн иргэд, ААН-үүдээс авч байгаа бөгөөд гадаад дотоод ажилтнуудын кемпүүдийн гал тогоо, бусад үйлчилгээнд орон нутгийн иргэдийг түр ажлын байраар хангаж байна. Тухайлбал, ТМЗ Инженерс Индиа Лимитед, Ерөнхий гүйцэтгэгч MEIL компаниуд нь эмч, инженер, оператор, туслах ажилтан, жолооч, харуул, гэрээт ажилтнуудаар тухайн бүс нутгийн 120 орчим хүнийг ажлын байраар хангаж байна.

Үйлдвэрийн болон Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж буй БНЭУ-ын EIL, MEIL болон БНХАУ-ын “Norinco International Limited” компаниуд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Дорноговь, Сүхбаатар, Дорнод аймгаас нийт 600 орчим хүнийг ажлын байраар хангаж байна.

Мөн дамжуулах хоолойн трассын дагуух 530 км технологийн зам нь Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийн өвс тэжээл, бараа материалын ачаа тээврийн гол зам болоод байна. Түүнээс гадна аймаг, сумдын зохион байгуулж байгаа баяр

наадам, спортын томоохон арга хэмжээнүүдэд хүн хүч, техник хэрэгслээр тусалж хамтран ажиллаж байгаагаас гадна зуд турхан, цахилгааны тасалдал зэрэг гэнэтийн осол, аваарын үед шаардлагатай арга хэмжээг авч, орон нутагт тусламж дэмжлэг үзүүлсээр ирсэн.

Тухайлбал, тайлант хугацаанд Ерөнхий гүйцэтгэгч MEIL болон Норинко компаниуд нь Дорноговь аймгийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх чиглэлд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажилласан.

ЕС.ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Компанийн үйл ажиллагаа болон төслийн хэрэгжилтийн явцыг харуулсан мэдээ мэдээллүүдийг компанийн албан ёсны вебсайт болон сошиал сувгуудад цаг тухай бүрд нь шинэчлэн байршуулж ажиллаж байна.

2025 оны хоёрдугаар улирлын байдлаар төслийн хэрэгжилт, ач холбогдлын талаарх мэдээлэл бүхий сурвалжилга, нийтлэл, гүйцэтгэх захирлын ярилцлага бүхий 20 орчим нэгж контент олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэгдээд байна. Компанийн албан ёсны вебсайт, ФБ болон твиттер хуудсанд 20 нэгж контентуудыг байршуулан нийтэлсэн. Тайлант хугацаа нь барилгын улирал таарч, үйлдвэрийн болон дамжуулах хоолойн барилга угсралтын ажил идэвхжиж буй тул бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх видео бичлэг бүхий дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Мөн 152 GB багтаамж бүхий гэрэл зураг, дуу дүрстэй бичлэгүүдийг архивлан хадгалсан. Төслийн хэрэгжилт, нийгэм эдийн засгийн ач холбогдлын талаар "MNB TV", "25-р суваг ТВ", "Монцамэ", "NTV", "UBN.mn", "zarig.mn", "Mining.mn" гэх мэт олон нийтийн хандалт өндөртэй томоохон мэдээллийн хэрэгслүүдэд контент, сурвалжлагууд гарсан.

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Контентын албаны мэргэжилтнүүд болох сэтгүүлч, зураглаачдаас бүрдсэн баг 2025.08.09-13-ны өдрүүдэд газрын тос дамжуулах хоолой, ГТБҮ-ийн талбайд ажиллав. Зураг авалтын үед болон контент бүтээх явцад мэдээ мэдээллээр хангаж ажилласан.

АРАВ.ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Төсөлд оролцогч талуудтай үр дүнтэй харилцаж, мэдээллээр хангах зэрэг төсөлд санаачилгатай оролцож буй байдлын хувьд:

МГТБҮ ХХК нь Засгийн газар, салбарын яам, хувьцаа эзэмшигч болох "Эрдэнэс Монгол" ХХК компани, хөрөнгө оруулагчид, ерөнхий гүйцэтгэгч компаниуд, инженер техникийн зөвлөх компаниуд, байгаль орчны хяналтын байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, иргэд, хуулийн зөвлөхүүд зэрэг оролцогч талуудад төслийн төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүү, техник, байгаль орчин, хууль эрх зүйн асуудалтай холбоотой мэдээллийг тогтмол цахим болон цаасан хэлбэрээр хүргэж, ERP систем, цахим сүлжээ, уулзалт, зөвлөгөө, хяналт, сургалт, хэлэлцүүлгийн хэлбэрээр хамтран ажиллаж байна.

Байгууллагын соёлын үнэлгээний хувьд:

Гүйцэтгэх захирлын 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/67 тоот тушаалаар "Компанийн ёс зүйн дүрэм"-ийг баталсан. Тус дүрэмд компанийн эрхэмлэх үнэт зүйлс, ёс зүйн зарчим, ажлын байранд баримтлах ёс зүйн хэм хэмжээ зэрэг байгууллагын соёлтой холбоотой заалтуудыг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал, Компанийн эрхэмлэх үнэт зүйлс, ёс зүйн зарчимд нийцүүлэн шилдэг сайн ажилтнуудыг урамшуулах замаар ажилтнуудад дэмжлэг үзүүлэн ажилладаг. Нийт ажилтнууд, ялангуяа инженерүүдийн мэргэшлийн байдлыг дээшлүүлэх үүднээс Төслийн менежментийн зөвлөх (TM3) Engineers India Limited болон Ерөнхий гүйцэтгэгч "Kalpataru Projects International

Limited”, “Megha Engineering and Infrastructure Limited” компаниуд, Лиценз эзэмшигч компаниудтай хамтран дотоод, гадаад сургалтуудыг зохион байгуулж байна. Мөн БНЭУ-ын Засгийн газрын Техник-Эдийн засгийн хамтын ажиллагаа (ИТЕС)-ны хүрээнд “МГТБҮ” ХХК ТМЗ компанитай хамтран боловсруулсан хөтөлбөрөөр БНЭУ-ын Нью Дели, Гуруграм зэрэг хотуудад онол практик хосолсон 3 удаагийн дунд хугацааны бүрэн тэтгэлэгтэй сургалтад одоогийн байдлаар 60 орчим инженерийг хамруулсан. Компанийн зорилго, үнэт зүйлсийг ажилтан нэг бүр мэддэг байх, түүнд хүрэх арга замыг хамтын хүчээр бий болгохын тулд ГТБҮ байгуулах төслийн хэрэгжилт, үр дүн, ойрын болон хэтийн төлөвлөгөөг танилцуулсан тайлан хурлыг тодорхой хугацаанд нийт ажилтнуудыг хамруулан зохион байгуулж, мэдээлэл өгч ажилласан. Инженер, мэргэжилтнүүд өөрийн хариуцсан ажлын хүрээнд судалгаа хийх, суралцсан зүйлсээ бусадтайгаа хуваалцах чиглэлээр 7 хоног бүр нийт инженерүүдийн хурлыг зохион байгуулж, мэдлэг хуваалцах өдөр болгон тогтмолжуулаад байна. Ажилтнуудын гаргасан санал санаачилгыг компанийн болон төслийн үйл ажиллагаанд тусган, шинэ санаа санаачилгыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Хууль тогтоомж, бодлого шийдвэр, үүрэг даалгаврын биелэлт болон Нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлж ажилласан байдлын хувьд:

“Эрдэнэс Монгол” ХХК-ний нэгдлийн хэмжээнд баталсан дараах дүрэм, журам аргачлалыг дагаж мөрдөн ажиллаж байна.

Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, Дотоод аудитын дүрэм, төлөөлөл хэрэгжүүлэх журам, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллаганы журам, Нэгдлийн зээлийн санхүүжилт олгох журам, Бизнес төлөвлөгөө боловсруулж, батлуулах журам, Нэгдлийн хуулийн этгээдийн зорилтот түвшин, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тодотголын төсөл боловсруулах аргачлал, Эрдэнэс Монгол нэгдлийн төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх журам, Нэгдлийн төслийг үнэлэх, эрэмбэлэх аргачлал, Төслийн төлөвлөлт, үнэлгээний баримт бичиг боловсруулах аргачлал, Төсөл хэрэгжүүлэх заавар боловсруулах аргачлал, Нэгдлийн хөрөнгө оруулалтын журам, Чиглэл хариуцсан зөвлөлүүдийн үйл ажиллаганы журам, Техникийн парк ашиглалт, бэлэн байдал цаг ашиглалт тооцох журам аргачлал зэрэг болно.

Тайлант хугацаанд МГТБҮ ХХК-ийн ТУЗ 2 удаа хуралдаж, нийт 6 тогтоол гаргаснаас Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаатай холбоотой журмуудыг баталснаас бусад 3 тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:

1. Зээлийн барьцааны гэрээнүүдэд нэмэлт өөрчлөлт оруулж, гарын үсэг зурах эрх олгох тухай;
2. Компанийн 2025 оны батлагдсан төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
3. Компанийн 2025 оны батлагдсан хөрөнгө оруулалтын төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Нэгдлийн “Сайн засаглал, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэх (Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, нийгэм засаглалын үзүүлэлтүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.) стратеги зорилго 4”-ийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн “Журам батлах тухай” 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар “Компанийн засаглалын бодлогын баримт бичиг”, “Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журам”, “Засаглал, нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам”, “Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталсан.

Түүнчлэн МГТБҮ ХХК-ийн Байгаль орчин, хөдөлмөр хамгааллын алба нь хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны хамгаалал, ажилчдын эрүүл мэнд, орон нутгийн хамтын ажиллагааны чиглэлээр ажиллаж байна.

АРВАН НЭГ. ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН АЖЛЫН ХҮРЭЭНД

МГТБҮ ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 2 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явуулж, удирдлага үйл ажиллагааны зорилго зорилтоо биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, компанийн хэмжээнд дотоод хяналтын үр ашигтай тогтолцоо, хяналтын соёлыг бий болгох зорилтыг тавьж ажилласан.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам” болон Гүйцэтгэх захирлын 2019 оны А/30 дугаар тушаалаар баталсан “Дотоод хяналтын журам”, 2024 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2025 оны төлөвлөгөөг 2 бүлэг 10 чиглэлтэйгээр боловсруулан Гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжилтийн явц, үр дүнг улирал бүр гаргаж, компанийн 2025 оны 3 дугаар улирлын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа.

Газрын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- 2025 оны компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг бэлтгэн гаргаж өгөв, тайлант оны 1-р улирлын төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн гаргаж үнэлгээ хийв
- Дотоод хяналтын 2025 оны төлөвлөгөөний дагуу компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд байнгын хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 3 дугаар улирлын байдлаар худалдан авах ажиллагаа хийгдсэн 3 нээлттэй тендер, 3 харьцуулалтын арга, 12 шууд худалдан авалтад дотоод хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд tender.gov.mn-д цахим худалдан авалтын системд хяналтыг хэрэгжүүлсэн.
- Хууль тогтоомж, төр засгийн шийдвэрүүд, ТУЗ-ийн шийдвэр, Гүйцэтгэх захирлын тушаалын хэрэгжилтэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.
- "Эрдэнэс Монгол" ХХК-д ТУЗ-ийн шийдвэр, дээд газраас ирүүлсэн тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж хүргүүлэн ажилласан. Дотоод аудитын газраас хийсэн компанийн 2023, 2024 оны эхний хагас жилийн санхүүжилт, түүний зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудит, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- Компанийн 2025 оны худалдан авах төлөвлөгөө, батлагдсан төсөвт тусгагдсан худалдан авалтад хяналт тавин ажилласан бөгөөд эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллого, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажилласан. Эхний хагас жилийн тооллогоор 1,094,777.1 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн тооллогод дотоод хяналтыг хэрэгжүүлж, тооллогын дүн, илтгэх хуудсыг санхүүгийн тайлантай тулган, биет тооллогыг хэрэгжүүлж ажилласан.
- Шилэн дансны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, байгууллагын цахим хуудсанд хууль заасан хугацаанд холбогдох мэдээллийг тогтмол оруулж байгаа эсэхэд байнгын хяналтыг тавьж ажиллаж байна. Улирал бүрийн дараа сарын 25-ны дотор Шилэн дансны

тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод хяналтын тайланг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлэн ажиллаж байна.

- "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор гүйцэтгэх захирлын 2025 оны А/20 дугаар тушаалаар Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж хүргүүлсэн.
- "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газраас компанийн 2023, 2024 оны эхний хагас жилийн санхүүжилт, түүний зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгсөн 25 зөвлөмжийг хэрэгжүүлэг төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газраас компанийн 2024 оны шилэн дансны нэгдсэн системийн бүртгэл, хөтлөлтөд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Эрсдэлийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Гүйцэтгэх захирлын 2024 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг боловсруулан батлуулж компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ хийж гарч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ олон улсын ISO 31000 стандарт, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийн дагуу чанарын аргачлалыг ашиглан, холбогдох газар нэгжүүдээс санал авах, асуулга хийх замаар гүйцэтгэсэн. Компанийн 2024 оны эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, эрсдэлийн нэгтгэсэн тайланг боловсруулан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн.

Компанийн 2025 оны эрсдэлийг бүртгэлийг холбогдох нэгж, газартай хамтран 63 эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээг хийж, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Толгой компаниас баталсан Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, “Нэгдлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх жишиг аргачлал”-ыг мөрдөж ажиллаж байна.

Эхний хагас жилд эрсдэлийн удирдлагын соёл төлөвшүүлэх чиглэлээр нэг удаа компанийн удирдлагуудад эрсдэлийн соёл болон эрсдэл бүртгэж хэвших талаар хэлэлцүүлэг зохион байгуулж 2025 оны эрсдэлийн бүртгэлд нэмж эрсдэл бүртгэж ажиллав.

Манай компани анх удаа 2024 оны 8 дугаар сараас эхлэн эрсдэлийн бүртгэлийг хийж эхэлсэн. Өөрийн батлуулсан эрсдэлийн удирдлагын журмын дагуу компанийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэж, журамд заасан зарчмын дагуу эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээний төлөвлөгөөг журмын 7.1.2-т заасны дагуу ангилан боловсруулж, Гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжилтийг эрсдэл хариуцагчаар хангуулан ажилласан. Нийт 2024 онд 18 эрсдэл бүртгэсэн ба үүнийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй учир хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан. Гэвч 2025 онд нийт 63 эрсдэл бүртгэж үүнээс 2024 оны 16 эрсдэл дахин бүртгэгдэж, шинээр 47 эрсдэл шинээр бүртгэж, үнэлгээ хийж, хариу арга хэмжээг төлөвлөсөн болно.

Компанийн эрсдэлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, түүний үнэн зөв байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Мөн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд зарим эрсдэлийг оруулан батлуулж ажиллаж эхэлсэн. 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд бүртгэсэн эрсдэлийн 50 хувийг оруулахаар ажиллаж байна.

АРВАН ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН ТАЛААР

Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/155 тоот тушаалын хавсралтаар компанийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсны дагуу тушаалын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Төлөөлөн удирдах Зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 20 дугаар тогтоолоор компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу газар нэгжүүд тайлант оны жилийн ажлын төлөвлөгөөг төлөвлөн сар бүр хэрэгжилтийг гаргаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 05 дугаар тогтоолоор компанийн зохион байгуулалтын бүтцэд нэмэлт өөрчлөлт орж орон тооны дээд хязгаарыг 128+1 байхаар компанийн бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан бүтцийн дагуу зарим ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн гэрээ, АБТ-ыг шинэчлэн байгуулав. Компанийн батлагдсан орон тооны хүрээнд шаардлагатай инженерүүдийг ажилд авч хүний нөөц бүрдүүлж байна. 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 93 үндсэн ажилтан, 11 гэрээт ажилтантай, нийт 104 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр баталсан ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 31 дүгээр тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр болон Газрын тос дамжуулах хоолой байгуулах төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гадаад ажилчдын урилга, визийн зөвшөөрөл, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл зэргийг хариуцан ажиллаж байна.

2025 оны 3 дугаар улиралд:

- ТМЗ EIL компанийн 5 ажилтанд урилга, визийн зөвшөөрөл болон 4 хүнд оршин суух, хөдөлмөр эрлэх зөвшөөрлийн албан бичиг гарган ажилласан.
- Ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын MEIL компанийн 336 инженер, техникийн ажилтанд урилга, визийн зөвшөөрөл, 455 ажилтанд оршин суух болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн албан бичиг, 6 ажилтанд үнэмлэх дахин хэвлүүлэх, 8 ажилтны зөрчлийг шийдвэрлүүлэн ажилсан. 2025 оны 10 дугаар сарын байдлаар үйлдвэрийн талбайд БНЭУ-ын 2000 ажилчид ажиллаж байна.

Газрын тос дамжуулах хоолойг барьж байгуулах ажлын Ерөнхий гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит “Норинко Интернэйшнл Кооперэйшн” компанийн 210 ажилтанд урилга, 424 ажилтанд оршин суух болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн албан бичиг гарган ажилласан. 10 дугаар сарын байдлаар төслийн талбайд БНХАУ-ын 400 иргэн бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцож байна.

АРВАН ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ХАБЭА-н ТАЛААР

ГТБҮ-ийн талбайд ажил гүйцэтгэж байгаа Ерөнхий гүйцэтгэгч болон түүний туслан гүйцэтгэгч компаниудын ХАБЭА-н нөхцөл, үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

- Орон нутагт томилолтоор ажиллаж байгаа ажилтнуудад "Тээврийн хэрэгслээр зорчих үеийн аюулгүй ажиллагааны журам"-ыг 45 удаа танилцуулсан байна. "Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын үед барилгын ажлын талбайд мөрдөх аюулгүй ажиллагааны журам"-ыг 7 хоногийн даваа гараг бүр орон нутагт ажиллаж байгаа инженер техникийн ажилтнуудад тогтмол танилцуулж байна. Мөн Бор хөөврийн говь дахь ус дамжуулах шугам хоолойн инженер техникийн

ажилтнуудад 14 хоногийн ээлж солилцох тухай бүрт аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж мөрдүүлж ажилласан байна.

- Үйлдвэрийн барилгын талбайд хүн, техник, тоног төхөөрөмж, бараа материал нэвтрэхэд хяналт тавих ажлыг ерөнхий гүйцэтгэгч Megha Engineering Infrastructures limited компанийн харуул хамгаалалтын баг болон орон нутгийн харуул хамгаалалтын "Их говийн наран" ХХК-иуд үүрэг гүйцэтгэж байна. Үйлдвэрийн талбай, Бор хөөвөрийн говь дахь ус дамжуулах шугам хоолойн өргөх станц, 11 худаг, үйлдвэрийн хотхон дээр нийт 60 орчим хяналтын камер ажиллаж байна. Үйлдвэрийн талбай руу нэвтрэх байгаа хүн, техник нэвтрэх үед бичиг баримт, зөвшөөрлийг шалган нэвтрүүлж байна.
- ГТБҮ-ийн талбайд ажил гүйцэтгэж байгаа MEIL, Norinco International Cooperation limited болон түүний туслан гүйцэтгэгч компаниудын ХАБЭА-н нөхцөл (хамгаалах хэрэгсэл, ажлын байр болон тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, хог хаягдал гм) үйл ажиллагаанд Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Улсын ахлах байцаагчтай хамтарсан хяналт шалгалт хийсэн.

Үйлдвэрийн талбай дахь 7 хоног тутмын хурал, ХАБ-ын зааварчилгаа өгч буй байдал



Ажиллах хүчний мэдээлэл

№	Гүйцэтгэгч байгууллагын нэр	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар
1	"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ХХК	103	103	103	103	103	103	102	102	106
2	"Engineers India Limited"	15	15	15	15	15	15	15	15	15
3	"Kalpataru Projects India Ltd", EPC-01	26	26	26	26	26	26	26	26	26
4	"Megha Engineering and Infrastructures Ltd", EPC 02	208	208	728	1601	2215	2300	2452	2405	2568
5	"Megha Engineering and Infrastructures Ltd", EPC 03			17	51	124	147	147	147	147
6	"Megha Engineering and Infrastructures Ltd", EPC-04	-	-	-	-	-	58	58	58	81

7	"Norinco International Cooperation Ltd"	15	19	40	45	348	556	523	584	529
8	"Хангайн бигэр" ХХК, 95-2, Оффис-11	18	28	30	26	-	19	-	-	-
9	"Баян тосон" ХХК, 95-1	1	1	1	14	5	18	20	12	15

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Үйлдвэрийн талбай, ус хангамжийн систем, Автозам, төмөр замын төслүүдэд гүйцэтгэж байна. Орчны хяналт шинжилгээний хүрээнд усны чанарын шинжилгээг Бор Хөөвөрийн 1-р худаг, 6-р худаг, өргөх станц, түүхий ус хадгалах сав зэрэг усны 5 эх үүсвэрээс дээж авч 2025 оны 06 дугаар сард Геологийн төв лабораторид шинжилгээнд хүргүүлж шинжилгээний үр дүнд үндэслэн мониторинг тайланг боловсруулан бичиж байна. Агаарын чанар, дуу чимээ, тоос тоосонцор, Ургамлын бичиглэлийн мониторинг судалгааг "Форест экологи Лаят" ХХК нь гэрээгээр гүйцэтгэсэн.
- 2025 оны ГТБҮ барих төсөл, Газрын тос дамжуулах хоолой барих төслийн Ус ашиглагчийн дүгнэлтүүдийг гаргуулж, гэрээ байгуулан ажиллаж байна.
- 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Үйлдвэрийн талбай болон Газрын тос дамжуулах хоолой барих төслийн хүрээнд 2 төлөвлөгөөг eic.mn сайтад төлөвлөгөөг илгээсэн. Үйлдвэрийн талбай нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тодотгол хийгдсэн дараа батлагдахаар буцаагдсан бол Газрын тос дамжуулах хоолойн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна.
- 38 МВт хүчин чадалтай шингэн түлшээр ажиллах Дулааны цахилгаан станц барих төслийн БОННҮ-ний тайланг хийж гүйцэтгүүлэхээр "Төгрөг баянхангай" ХХК шалгарч ажлаа эхлүүлээд байна.
- Төслийн БОННҮ-ний тайлангийн нэмэлт тодотгол тайланг хийж гүйцэтгүүлэхээр тендерийн хуулийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдөр tender.gov.mn сайтад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.
- Давст XXXI талбайд гүйцэтгэх газрын тосны хайгуулын ажлын Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.


АРВАН ДӨРӨВ. БУСАД АЖИЛ

- 2025.07.30 өдөр БНЭУ-аас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Атул Малхари Готсурвед Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцыг танилцуулсан. Энэ үеэр Элчин сайд төсөл хэрэгжүүлэгч, төслийн менежментийн зөвлөх, ерөнхий гүйцэтгэгч компаниудын удирдлагуудтай үйлдвэрийн талбайд хурал уулзалт хийж, үйлдвэрийн талбайд өрнөж буй бүтээн байгуулалттай биечлэн танилцаад EPC02, 03 багц ажлуудын хүрээнд хийгдэж буй ажлуудад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн.



- 2025.08.19 өдөр Монгол Улсын их хурлын гишүүн, Аж үйлдвэр, Эрдэс баялгийн сайд Г.Дамдинням Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй ГТБҮ-ийн талбайд ажиллав. Сайд Г.Дамдинням болон БНЭУ-ын элчин сайд А.М.Готсурве, Япон улсын элчин сайд Игавахара Масарү нар төслийн бүтээн байгуулалтын ажлын явцтай биечлэн танилцсанаас гадна төслийн хэрэгжилтийн явцын талаар төсөл хэрэгжүүлэгч болон ерөнхий гүйцэтгэгч компаниуд дэлгэрэнгүй мэдээлсэн.





- 2025.08.21-24-ний өдрүүдэд Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Бямбацогтын Орхон, Дархан-Уул аймагт ажиллах үеэр “Эрдэнэс Монгол” нэгдлээс Эрдэнэт хотод зохион байгуулагдсан “2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа - Бүтээн байгуулалт, өвөлжилтийн бэлтгэл” зөвлөгөөнд Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг оролцож, ГТБҮ байгуулах төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явцыг танилцуулсан. Уг үйл ажиллагааны үеэр Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг төсөл хэрэгжүүлэгч компанийн болон төслийн хэрэгжилтэд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудын талаар Эрдэнэс Монгол ХХК-ийн захирлуудтай уулзалт хийсэн.



- 2025.09.17 өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн удирдлагууд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн байранд Гүйцэтгэх захирал, нэгжийн удирдлагуудтай авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үеэр АТГ-ын ажилтнуудад төслийн хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл танилцуулга хийж, ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлүүдийг хэрхэн тодорхойлох, авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, мэдээлэл солилцсон.




- 2025.09.11-13 өдрүүдэд АҮЭБЯ-наас зохион байгуулсан “Mining week” экспод “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, инженер, мэргэжилтнүүд оролцож, төслийн хэрэгжилт, ач холбогдлын талаар олон нийтэд мэдээ мэдээлэл түгээн ажиллав.



- 2025.09.23-27 өдрүүдэд БНЭУ-ын Гадаад хэргийн яамны Зүүн Ази хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга ноён Периасими Кумаран Монгол улсад айлчлав. Айлчлалын хүрээнд төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцсан. ГТБҮ-ийн бүтээн байгуулалтын ажлыг төсөл хэрэгжүүлэгч компанийн удирдлага, инженер мэргэжилтнүүд төслийн хэрэгжилтийг танилцуулснаас гадна төслийн менежментийн зөвлөх Engineers India Limited компани, Ерөнхий гүйцэтгэгч Megha Engineering and Infrastructures Ltd компанийн удирдлагууд ажлын явц, нарийвчилсан төлөвлөгөөг дэлгэрэнгүй мэдээллээ. Мөн энэ үеэр төслийн менежментийн болон хяналтын хурал хийж, цаашид авах арга хэмжээний талаар талууд санал солилцсон.



- Мөн айлчлалын бүрэлдэхүүн болон МГТБҮ ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, Гэрээ эрх зүйн газрын дарга У.Чинзориг, Ахлах мэргэжилтэн О.Энхбаяр нар АҮЭБ-ийн сайд Г.Дамдинням болон Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв нартай албан уулзалт хийсэн.





Эрчим хүчний эрх чөлөөг эх орондоо!

“МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ХХК